

**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ,  
СУМДЫН 2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2023.07.05

Сүхбаатар сум

**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:**

**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:**

Уулзалт, хамтын ажиллагааны чиглэлээр:

Сэлэнгэ аймаг Дээрэт олон улсын байгууллагатай 1998 оноос эхлэн хамтран ажиллаж ирсэн бөгөөд 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдөр тус байгууллагын Ази бүсийн захирал Жонн Маккюне, түүний эхнэр Дэбора Маккюне, Хуульч Кэн Барроу, Хэнри Савстром, Так Мочизуки, Монгол дахь байгууллагын захирал Д.Пүрэвжаргал болон удирдах бүрэлдэхүүнийг хүлээн авч уулзлаа.

Дээрэт олон улсын байгууллага нь өнгөрсөн хугацаанд Сэлэнгэ аймагтай нягт хамтын ажиллагаатай байж хүн амын эрүүл мэнд, эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг дэмжих чиглэлийн дэмжлэг, тусламжийг тогтмол үзүүлж ирсэн билээ.

Сургалт, зөвлөгөөний чиглэлээр:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанаас аймгийн Засаг даргын Тамгын газар, Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай хамтран аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид зэрэг 200 гаруй оролцогчтой төсөв төлөвлөх, батлах, гүйцэтгэлд тавих хяналтын талаар зохих мэдээлэл, цаашид анхаарах асуудлын талаар цахим сургалтыг 2023 оны 06дугаар сарын 15-ны өдөр зохион явууллаа.

Сургалтаар 2024 оны төсөв батлахад анхаарах зүйл, Аудитын дүгнэлтээр гардаг гол зөрчлүүдийн талаар, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын талаарх анхаарах асуудлууд, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих тухай, аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн анхаарвал зохих зарим асуудлын талаар мэдээлэл хийлээ.

Мөн хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох замаар энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлтийг сайжруулах зорилгоор Монгол улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс Сэлэнгэ аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран “Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлгийг 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдөр зохион байгууллаа.

Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргийн 2022 оны тайлан, мэдээг сонсож энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд орон нутаг дахь төрийн байгууллагуудын зүгээс хэрхэн анхаарал хандуулж ажиллах талаараа хэлэлцэн зөвлөлдлөө.

Хэлэлцүүлэгт Монгол улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажлын хэсэг, Сэлэнгэ аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн гишүүд, Ерөө, Хүдэр,

Орхонтуул, Мандал сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга бөгөөд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга нар, албаны бусад хүмүүс оролцлоо.

Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга бөгөөд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нарыг чадавхжуулах, салбар зөвлөлийн ажлын үр дүнг сайжруулах зорилгоор 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдөр аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс сургалт зохион байгууллаа.

Сургалтад Сэлэнгэ аймгийн 17 сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга бөгөөд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нар оролсон.

Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанаас khural.mn сайтын хөтлөлт хөгжүүлэлтийг сумдад хариуцан ажилладаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга, Хурлын ажлын албаны ажилтнуудад 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдөр сургалт зохион байгууллаа.

Сургалтыг khural.mn вэб сайтыг шинэчлэн хөгжүүлж буй Онлайн солюшнс ХХК-ийн захирал, багш Д.Соёл-Эрдэнэ удирдан явуулж Khural.mn веб сайтыг тухай, хөгжүүлэлтийн өнөөгийн байдал, шинээр хийгдсэн модулиудын танилцуулга, мэдээ, мэдээлэл оруулах, тогтоол шийдвэрийн бүртгэл, ИТХ-ын Төлөөлөгчдийн бүртгэл, асуулт хариулт, дасгал ажил зэрэг сэдвээр хийгдлээ.

Уг сайт нь Швейцарийн Засгийн газрын санхүүжилттэй "Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь" төслийн дэмжлэгээр бий болсон Монгол улсын аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын нэгдсэн цахим хуудас юм.

Олон нийтийн арга хэмжээ:

Энэ онд НҮБ-аас Авлигын эсрэг конвенц батлагдсаны 20 жилийн ойг тохиолдуулан "Дэлхий нийтээрээ авлигын эсрэг нэгдье" уриалгыг дэвшүүлэн, тус конвенцид нэгдсэн улс орон бүр зорилтот үйл ажиллагаа хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг "Авлигатай тэмцэх жил" болгон зарласан бөгөөд тус жилийн хүрээнд Авилгатай тэмцэх газраас "Авлигын эсрэг НЭГДБЕ" үндэсний хэмжээний нөлөөллийн аяныг эхлүүлээд байна.

"Сэлэнгэ марафон"-д оролцогчид хууль бус үйлдэлтэй үл эвлэрэх, авлигыг үл тэвчих үзэл, хандлагыг төлөвшүүлэх, хүнд суртал, чирэгдлийг арилгах, төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдлыг хангах, авлигын эрсдэлийг бууруулж, иргэдийг авлигын эсрэг шүгэл үлээхэд түлхэц үзүүлэх тус аяныг дэмжин нэгдлээ.

### **Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:**

ОХУ-ын БНБУ-ын түүхт 100 жилийн ойн баярын арга хэмжээ 2023 оны 06 дугаар сарын 02,03-ны өдрүүдэд Улан-үдэ хотод зохион байгуулагдаж урилгаар оролцлоо.

Мөн арга хэмжээний хүрээнд тус улсын тэргүүнтэй албан уулзалт хийж цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцлоо.

БНХАУ-ын Хар мөрөн муж хоорондын уламжлалт найрсаг хамтын ажиллагааны хүрээнд Харбин хотын 32 дахь удаагийн үзэсгэлэн яармаг худалдаанд аймгийн төлөөлөл оролцлоо.

Энэхүү үзэсгэлэн яармаг худалдаанд оролцсоноор 2 орны аж ахуйн нэгж байгууллагуудын хамтын ажиллагааг бий болгох, хамтарсан үйлдвэрлэл

худалдааны түншлэл гэрээ байгуулахад дэмжлэг үзүүлэх зэрэг асуудлаар санал солилцож тус үзэсгэлэн яармагт аймаг орон нутгаас аж ахуйн нэгжүүдийг хамруулах талаар судлах, хөрөнгө оруулалт татах, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх зэрэг олон талт асуудлыг харилцан судлахаар тохиролцлоо.

Манай аймагт Төрийн албаны зөвлөлийн гишүүн Б.Идэрчулуун, Маргаан хянан шалгах газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, Маргаан хянан шалгах газрын ахлах шинжээч Я.Өлзиймөнх, Захиргаа удирдлагын газрын референт Д.Наран-Отгон нарын бүрэлдэхүүнтэй Төрийн албаны зөвлөлийн ажлын хэсэг 6 дугаар сарын 12-14-ний өдрүүдэд ажиллаж байна. Баг бүрэлдэхүүн аймгийн Засаг дарга болон Төрийн албаны зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөлийн гишүүдтэй уулзан санал солилцож, аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар хэлтэс, албадын дарга, мэргэжилтнүүд, Сүхбаатар, Алтанбулаг, Шаамар сумын төрийн албан хаагчдын төлөөллийг хамруулан төрийн албаны хууль тогтоомжийн тухай сургалт зохион байгуулж, санал хүсэлтийг нь сонсож, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар, Шинэ сэргэлтийн бодлогын Хурдасгуур төвтэй хамтран "Процессын дахин инженерчлэл" сэдэвт уулзалт хэлэлцүүлгийг 6 дугаар сарын 19-ний өдөр аймгийн төвд зохион байгуулж, 6 дугаар сарын 19-22-ны өдрүүдэд аймгийн Нийгмийн даатгалын газар, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, 6 дугаар сарын 23-ны өдөр Шаамар сумын төлөөлөлтэй уулзалт, хэлэлцүүлэг хийлээ.

Аймгийн төвд хийсэн уулзалтад Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж "Процессын дахин инженерчлэл хийх талаар баримталж буй Засгийн газрын бодлого", Шинэ сэргэлтийн бодлогын Хурдасгуур төвийн захирал Б.Дөлгөөн "Төрийн чадамжийг бүрдүүлэх нь", Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Тандалт судалгааны багийн ахлагч Б.Анар "Төрийн байгууллагад Процессын дахин инженерчлэл хийх нь", Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Ж.Эрхэмбаатар "Хот хөдөөгийн сэргэлт ба цахимжилт" сэдэвт илтгэлүүдийг тус тус танилцуулж 450 гаруй төрийн албан хаагчид хамрагдлаа.

Тус төсөл нь аймгийн Нийгмийн даатгалын газар, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, болон Шаамар суманд эхлэн хэрэгжих бөгөөд Процессын дахин инженерчлэл хийснээр дараах үр дүнд хүрэх зорилттой байна. Үүнд:

-Иргэдийн төрийн үйлчилгээг авахын тулд туулдаг шат дамжлагын тоог багасгана.

-Төрийн үйлчилгээг иргэдэд илүү шуурхай хүргэх боломжтой болно.

-Төрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой албан хаагчийн ажлын ачааллыг илүү тэнцвэртэй зохион байгуулах боломжтой болно.

-Төрийн үйлчилгээг хүргэх илүү олон сонголттой болж, иргэд хүссэн хэлбэрээр, хялбараар авах боломж бүрдэнэ.

-Захиргааны байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг илүү оновчтой болгоно.

-Төрийн албаны бүтээмж, чадамж дээшилж, төрийн үйлчилгээг үзүүлж буй албан хаагч, үйлчилгээ авч буй иргэн аль алиных нь сэтгэл ханамж нэмэгдэх ач холбогдолтой.

Мөн Удирдлагын Академийн "Төрийн захиргааны албан хаагчийн мэргэшсэн байдал, түүний шалгуур үзүүлэлт" сэдэвт Доктор Ж.Алтайбаатар ахлагчтай судалгааны баг манай аймагт 6 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд ажилласан.

### **Онцгой байдлын ажил үйлчилгээний талаар:**

Тайлангийн хугацаанд ой, хээрийн гал түймрийн 4, объектын гал түймрийн 14, мал, амьтны гоц халдварт өвчний 3, усны осол 2 нийт 23 удаагийн гамшиг осол, гал түймрийн дуудлагаар гарч иргэн, аж, ахуйн нэгж байгууллагын 112 сая төгрөгийн өмч хөрөнгийг гал түймэр, гамшиг ослын аюулаас авран хамгаалж, гол мөрний усанд осолдсон 3 тохиолдол гарлаа.

Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 1 дүгээр сарын 09-ний өдөр баталсан “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний удирдамж, 2023 оны 2 дугаар сарын 07-ны өдөр баталсан “Стратегийн команд шатбын сургууль” зохион байгуулах тухай тушаал, Онцгой байдлын ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх газрын даргын 2022 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 10/1071 дүгээр албан бичгээр ирүүлсэн үүрэг чиглэлийн хүрээндиргэд, олон нийтэд, газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх мэдлэг, ойлголтыг мэдээллийн бүх төрлийн сүлжээ, хэрэгслээр дамжуулан олгох “Бэлэн бай” нөлөөллийн аяныг 2023 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс 6 дугаар сарын 6-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсан.

Стратегийн команд штабын сургуулийн бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөний хүрээнд аймгийн 8 Гамшгаас хамгаалах алба, 10 мэргэжлийн анги **нийт 18 гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд** газар хөдлөлтийн гамшигтай тэмцэх чиглэлээр тодотгол хийн ажиллалаа.

“Бэлэн бай” аяны хүрээнд Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжийн дагуу иргэдэд газар хөдлөлтийн аюул, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах талаар ойлголт, мэдээлэл өгөх, урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээллийг түгээх зорилгоор хүн ам олноор цуглардаг дараах газруудад “Бэлэн бай” сурталчилгааны самбарыг 6 байршилд 8 самбар байршуулан ажилласан.

Мөн“Гал түймэр гарах шалтгаан нөхцөл” цуврал 3 төрлийн сэрэмжлүүлэг шторк бэлтгэж олон нийтийн сүлжээгээр цацаж хандалтын тоо 31,000 хүрсэн байна.

### **Стандарт, хэмжил зүйн үйл ажиллагааны талаар:**

2023 оны 6 дугаар сарын 15-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулагдсан Ази, Номхон далайн бүс нутгийн хэмжил зүйн хөтөлбөр /APMP/ Олон улсын байгууллагын 2023 оны хагас жилийн хурал, уулзалтад аймгийн төлөөлөл оролцлоо.

Стандарт, хэмжил зүйн газраас эхлүүлж буй “Юманд хэмжээ бий” аян нь 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн Улс орон даяар хүрч байгаа бөгөөд түүний хүрээнд мэдээллийг түгээн ажиллаж байна.

2023 оны 06 дугаар сарын байдлаар өссөн дүнгээр улсын төсвөөс шилжүүлгээр 169,624,1 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 37,000,0 мянган төгрөг нийт 206,624,1 мянган төгрөгийн санхүүжилт тавигдсанаас батлагдсан төсвийн зориулалтын дагуу төсвийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн холбогдох дүрэм, журамд нийцүүлэн зарцуулан ажиллаж байна.

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд 80,542,0 мянган төгрөгийн орлого бүрдүүлснээс дээд шатны газар /Стандарт хэмжил газар/-т 10,000,0 мянган төгрөгийн лабораторийн орлогыг төвлөрүүлэх хуваарийн дагуу төвлөрүүлж ажиллалаа.

**Үйлчилгээний баталгаажуулалт:**Цагааннуур, Сайхан, Ерөө, Хүдэр, Сүхбаатар сумын 43 иргэн, аж ахуйн нэгжийн 46 үйлчилгээний газрын үйл

ажиллагаанд тохирлын үнэлгээ хийж, “MNS 5021-1:2019 Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага”, “MNS 4946:2019 Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага”, “MNS 5738:2007 Дэн буудалд тавих шаардлага”, “MNS 5160:2020 Үс засах үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага” стандартын шаардлагад нийцсэн 19 үйлчилгээний газарт баталгаажуулалтын салбар зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэж тохирлын гэрчилгээ олгосон.

Экспорт баталгаажуулалт: Ерөө суманд “Болдтөмөр Ерөө гол” ХХК, “Инфинити спэйс” ХХК аж ахуй нэгжүүдийн олборлодог “Металлургид хэрэглэх төмрийн хүдэрт тавих ерөнхий шаардлага ба төмрийн хүдрийг орлох түүхий материалын ангилал- MNS 6249:2011” стандартын шаардлагад нийцсэн төмрийн хүдрийн 62 удаагийн тээвэрлэлтэнд баталгаажуулалт хийж, экспортын гэрчилгээ олгосон.

Хэмжил зүйн лаборатори:

Эзлэхүүн хэмжлийн төрлөөр-2 шатахуун түгээх газрын 5 хэмжих хэрэгслийг шалган баталгаажуулсан.

Шалгалт тохируулгаар-Гаалийн газрын лабораторийн 9 лабораторийн хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга хийсэн.

Массын хэмжлээр-3 сумдын худалдаа үйлчилгээ эрхлэгч, эрүүл мэндийн төвийн 60 жин, туухайг шалган баталгаажуулсан.

Дулаан, даралтын хэмжлийн төрлөөр-Эмнэлэг, эмийн сангуудын 19 ш термометр, цусны даралтын аппарат 8 ш шалган баталгаажуулсан.

Цахилгаан хэмжлийн төрлөөр-Мандал, Сүхбаатар сумын айл өрхийн 600 ш цахилгааны 1 фазын тоолуурыг шалган баталгаажуулсан.

Итгэмжлэгдсэн лаборатори:Итгэмжлэгдсэн лаборатори нь нийт 25 аж ахуй нэгжийн 71 дээжинд 376 үзүүлэлтээр шинжилгээ хийж 2,782,200 төгрөгийн нэхэмжлэх үүсгэн 1,544,300 төгрөг нь төвлөрсөн байна.

**Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:**

6 сард1003 баримтаар 16,9тэрбум төгрөгийн төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог хянан гүйцэтгэлээ.

Аймгийн 5 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн мэдээг гаргаж Статистикийн хэлтэст хугацаанд нь хүргүүлж, мөнсарын аймгийн орлогын гүйцэтгэлийн мэдээг Татварын хэлтэстэй тулган баталгаажуулж, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр аймгийн вэб сайт, шилэн данс болон ил тод самбарт байршуулан ажиллаж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөоруулалтын санхүүжилтийг сум бүрд хуваарилан тавьж, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт олгосон.

Өргөн хэрэглээний барааны үнэ:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2022–VI	2023 – VI	$\frac{2023 - VI}{2022 - VI}$
<b>1.ХҮНСНИЙ БАРАА</b>				
1	Талх, гурил, будаа	1 500	2 200	135.7
	Гурил /Алтантариа, I зэрэг, кг/	1 500	2 200	142.9
	Талх /ороннутгийн, ш/	1 400	1 900	115.6
	Нарийнбоов /кг/	3 500	5 000	115.6
	Будаа /кг/	3 200	3 700	

	Элсэнчихэр /кг/	3 200	3 700	137.0
<b>2</b>	<b>МАХ МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН</b>			114.8
	Хониныхмах /кг/	10 000	13 700	114.7
	Үхрийнмах /кг/	13 500	15 500	123.2
	Адууныхмах /кг/	9 500	10 900	2.0
	Ямааныхмах /кг/	9 500	11 700	104.4
	Дотормах, цувдай /цусгүй/	4 000	8 000	
	Хиам /чанасан, кг/	15 800	16 500	147.1
<b>3</b>	<b>СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ</b>			104.4
	Сүү /задгай, л/	1 700	2 500	111.5
	Сүү / савласан, л/	4 500	4 700	99.2
	Тараг /задгай, л/	2 600	2 900	
	Хорхойааруул /задгай, чихэртэй, кг/	25 000	24 800	136.7
	Айраг /л/	5 000		100.0
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	6 000	8 200	
	Өндөг /ш/	450	450	125.6
<b>4</b>	<b>Бүхтөрлийнөөхтос</b>			148.0
	Ургамлынтос /л/	8 600	10 800	116.4
	Өөхөнтос /кг/	2 500	3 700	167.7
	Шартос /кг/	25 000	29 100	
	Масло /задгай, кг/	6 500	10 900	113.3
<b>5</b>	<b>ХҮНСНИЙ НОГОО</b>			57.1
	Төмс /кг/	1 500	1 700	100.0
	Лууван /кг/	3 500	2 000	65.7
	Манжин /кг/	3 500	3 500	109.4
	Байцаа /кг/	3 500	2 300	103.9
	Сонгино /кг/	3 200	3 500	131.8
	Өргөстхэмх /шилтэй, дарсан/	7 600	7 900	
	Алагсалат /шилтэй, Urbanek, 630гр/	4 400	5 800	101.2
<b>2. ШАТАХУУН</b>				
	Бензин А - 80	2 450	2 480	105.0
	Бензин А - 92	2 500	2 500	146.7
	Дизелийнтүлш	3 380	3 550	146.7

### **Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:**

Авлигатай тэмцэх газрын хөтөлбөр, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор “Шударга удирдагч, шударга төрийн албан хаагч” аян, “Шүгэл үлээх ажиллагаа”-ны хүрээнд зохион байгуулж буй “Нэгдье”, “Үгүй гэж хэлээд өөрчилье” авлигын эсрэг нөлөөллийн аяныг 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрөөс аймгийн хэмжээнд эхлүүлж, тайланг нэгтгэх ажлыг хийж байна.

Монгол Улсын Засгийн газартай хамтран Төрийн албан хаагчийн ёс зүй сахилга хариуцлагын тухай хуулийн төслийг 380 төрийн албан хаагчдад танилцуулж, хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Хүний эрхийг хангах Үндэсний хорооны 2023 оны 01 дүгээр тогтоолоор баталсан “Орон нутаг дахь хүний эрхийн төлөв байдлыг тайлагнах, илтгэх журам”-ын 2.2-т заасны дагуу аймгийн хэмжээний хүний эрхийн төлөв байдлын тайланг 4 бүлгийн хүрээнд нэгтгэн хугацаанд нь хүргүүлж, Засгийн газрын Хэрэг эрхлэх

газарт 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдөр цахимаар тайланг илтгэх ажлыг зохион байгууллаа.

**Аймгийн Цагдаагийн газар:** 2023 оны 06 дугаар сарын байдлаар нийт 293 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 56 (16.0%)-аар бага үзүүлэлттэй, нийт гэмт хэргийн 84 (28.7%) нь согтуугаар үйлдэгдсэн байна. Иргэн болон байгууллагад нийт 1329.1 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны үеэс 3934.4 (3.9 дахин) сая төгрөгөөр буурсан байна. Учрсан хохирлоос 528.3 сая төгрөгийг нөхөн төлүүлж, нөхөн төлөлт 64.6 хувьтай байна.

**Аймгийн Шүүх шинжилгээний хэлтэс:** 2023 оны 06 дугаар сард шүүх эмнэлгийн шинжилгээний тоо 31, хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ 24, криминалистикийн шинжилгээ 2, цогцост хийсэн шинжилгээний тоо 7, магадлан шинжилгээ 7, тусгай шинжилгээ 13-г хийж ажилласан.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар:** Хуулиа дээдэлж, Үүргээ биелүүлье, Хүүхдийн тэтгэлэг, Хүүхдийн ирээдүй аяны хүрээнд 382 хүүхдийн тэтгэлгийн материалд шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явуулж 348,248,5 мянган төгрөгийг тэтгэлэг авагчид олгосон, төлбөрийн 452 гүйцэтгэх хуудас материалаас 48 гүйцэтгэх хуудасны 84518,3 мянган төгрөгийг бодитой биелүүлж 413 гүйцэтгэх хуудасны 8,216,601,2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хорихоос өөр төрлийн ял, албаадлагын арга хэмжээ авагдсан нийт 201 этгээдэд хяналт тавьж 89 этгээдэд холбогдох материалыг дуусгавар болгон 112 ялтан, этгээдэд холбогдох материалд хяналт тавьж ажиллаж байна.

**Улсын бүртгэлийн хэлтэс:** Тайлант хугацаанд Улсын бүртгэлийн чиглэлээр дараах үйлчилгээг иргэдэд түргэн, шуурхай үзүүлж ажиллалаа.

Иргэний бүртгэлийн талаар:

-Төрсний бүртгэл - 107 /эрэгтэй-65, эмэгтэй-42/

-Гэрлэлтийн бүртгэл – 30

-Гэрлэлт цуцалсны бүртгэл – 10

-Үрчлэлт – 1

-Эцэг, эх тогтоолт – 02 /үүнээс эрэгтэй 01, эмэгтэй 01/

-Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл – 6

-Нас баралт – 44

-Нийт олгосон иргэний үнэмлэх – 295

-Шинээр олгосон иргэний үнэмлэх – 114

-Дахин олгосон иргэний үнэмлэх – 40

-Иргэний үнэмлэхийн хугацаа дуусаж авсан – 140

-Гадаад паспорт олголт – 357

-Аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн-70 /насанд хүрсэн 45, хүүхэд 25/

-Хот доторх шилжилт хөдөлгөөн - 84 тус тус бүртгэгдсэн байна.

Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн талаар:

-Хүлээн авсан мэдүүлгийн тоо – 741

-Анхны бүртгэл – 201

-Өмчлөх эрх шилжих гэрээ – 158

-Барьцааны гэрээ – 332

-Бүртгэлд өөрчлөлт оруулах – 27

-Лавлагаа хуулбар – 12

-Нийт бичигдсэн гэрчилгээний тоо – 382

Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө, өмчлөх эрхийн улсын бүртгэлийн талаар:

- Хүлээн авсан мэдүүлгийн тоо- 819
- Анхны бүртгэл- 43
- Өмчлөх эрх шилжих гэрээ-115
- Барьцааны гэрээ- 629
- Бүртгэлд өөрчлөлт оруулах- 19
- Лавлагаа хуулбар-10
- Нийт бичигдсэн гэрчилгээ-175

### **Дөрөв. Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:**

**Боловсролын чиглэлээр:** Бага боловсролын “Унших /EGRA/ ба тоо бодох /EGMA/ чадварыг хөгжүүлэх арга зүй”-н харилцан туршлага судлах, суралцах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор Аймгийн бага ангийн багш нарын зөвлөгөөнийг зохион байгуулж, бага ангийн нийт 389 багш, зочид төлөөлөгч, сургалтын менежер, мэргэжилтэн нийт 402 хүн оролцож, “Шилдэг арга зүйн 10 илтгэл тавигдаж хэлэлцэн, ЭГРА, ЭГМА арга зүйн хэрэглэгдэхүүнээр үзэсгэлэн гаргаж, сайн туршлагаа танилцуулж, түгээн дэлгэрүүлэн шилдэг 10 багш, ЗАН сургуулиудыг урамшууллаа.

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр "Боловсрол" хотхонд мэргэжлийн боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг 3 байгууллагын болон МУИС, Идэр ИС, Глобаль удирдагч ИС, ОХУ-ын Буриадын Бүгд найрамдах улсын их сургуулиудын танилцуулгыг хүргэж, үндэсний бичиг соёлоо сурталчилж, "Оюун ухааны академи"-ийн сэтгэхүй хөгжүүлэх тоглоом, наадгайг үзүүлж, зөв бичих дүрмийн "Аялгуу" аппликейшнээр мэдлэг, чадварыг сорилоо

2023 оны 6-р сарын 08-09-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо ХААИС, Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлөөс хамтран зохион байгуулсан аймаг, орон нутаг дахь Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийн дарга, Нарийн бичгийн дарга нарыг хамруулсан, “ИННОВАЦЫГ ОРОН НУТАГТ” сэдэвт мэргэжил, арга зүйн сургалтад мэргэжилтэн Ц.Золжаргал хамрагдсан. Сургалтын үеэр санал хэлэлцүүлэгт оролцож, "Орон нутагт инновацын төсөл хэрэгжүүлэх, грант олгох үлгэрчилсэн журам"-ын төсөлд саналаа өгсөн. Мөн ХААИС-ийн AGRI SHOWCASE буюу ХАА-н салбарт бий болсон инновацын шийдлүүдийг бизнес эрхэгч, хөрөнгө оруулагч нарт танлцуулах “ХАА-н салбар дахь инновац ба хөрөнгө оруулалт” арга хэмжээний нээлтэд оролцож, үзэсгэлэнтэй танилцав.

2023 оны 6 дугаар сарын 15-18 ны өдрүүдэд зохион байгуулагдсан элсэлтийн ерөнхий шалгалтад 1038 шалгуулагч 10 хичээлээр бүртгүүлж давхардсан тоогоор 3215 шалгалт өгөхөөр бүртгүүлсэн бөгөөд 2966 шалгуулагч 114 зааланд шалгалтад орлоо. Ирц 92,3 хувьтай байв. Сэлэнгэ аймгийн ЭЕШ-ыг БҮТ-ийн комисс, аймгийн боловсрол, шинжлэх ухааны газар, Сүхбаатар сумын 1-р сургууль, аймгийн тагнуулын газар, цагдаагийн төлөөлөгчид хамтран амжилттай зохион байгууллаа.

Ерөнхий боловсролын 35 сургуулийн 33 нь танхимын бус цахим хэлбэрээр сургалт зохион байгуулах боломжийг бүрдүүлсэн ба Боловсролын ерөнхий газар, Боловсрол шинжлэх ухааны газар, Боловсролын үнэлгээний төв болон бусад байгууллагаас зохион байгуулсан мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалт, сонголтод сургалт, үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, үндэсний шинжээч багшийн зэрэг цахим сургалтад БШУГ-ын мэргэжилтнүүд, ЕБС-ийн 127 удирдах ажилтан, 962 багш, нийт 1089 хүн хамрагдан сертификат авлаа.



Багш нар Google Forms дээр суралцагчдаас авах шалгалтын материал боловсруулан давхардсан тоогоор 2145, дунд анги 554, ахлах анги 1455 цахим сорилго авах суралцагчдын мэдлэг чадварыг оношлон агуулгаа төлөвлөн сургалтын үйл ажиллагааг зохион байгуулсан. 2022-2023 оны хичээлийн жилд Цахим сургуульд ЕБС-ын 10-р ангийн 516 сурагч 16 хичээлийг сонгон судалж сургууль бүр шинээр тохижуулсан цахим танхимдаа таблет ашиглуулан цахим сонгон судлах хичээлдээ хамрагдах боломжийг бүрдүүлэн ажиллалаа.

Боловсрол Шинжлэх Ухааны яам, Дэлхийн банкнаас хамтран хэрэгжүүлсэн “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд бага боловсролын “Эх хэлний уншаад ойлгох чадварыг хөгжүүлэх”-д зориулан 1,7 сая төгрөгийн үнэ бүхий “Бага ангийн сурагчдын унших чадварыг хөгжүүлэх, үнэлэх зарим арга, хэрэгсэл” гарын авлага, бага боловсролын 379 багшид нийлүүлсэн. Мөн аймгийн төвөөс бусад ерөнхий боловсролын сургуулийн бага боловсролын багш, суралцагчдад зориулан монгол хэл, математик, хүн ба байгаль, аймгийн төвийн Сүхбаатар сумын 3 дугаар сургуулийн “Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим”-д зориулан хэл ярианы хөгжил, танин мэдэхүйн үйл ажиллагаа, дүрслэх урлаг, технологи гэсэн 13,6 сая төгрөгийн үнэ бүхий 5 төрлийн нийт 951 ширхэг “Бие даан суралцах дасгал ажлын дэвтэр” нийлүүлэгдэж, сургуулиудад хүлээлгэн ажиллалаа.

**Эрүүл мэндийн чиглэлээр:** Сүүлийн жилүүдэд эмч, эмнэлгийн мэргэжилтний ур чадвар нэмэгдэж байгаа хэдий ч орон нутаг дахь эмнэлгийн тусламж үйлчилгээ харилцан адилгүй, өвчлөлийн бүтэц өөрчлөгдөж халдварт бус өвчин, осол гэмтэл өсөх болсон. Иймд анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч нарын мэдлэгийг сэргээх, ур чадварыг нэмэгдүүлэх шаардлагатай болж байгаа юм. Сургалтыг Эрүүл мэндийн газрын Эрдмийн жим сургалтын танхимд 2023 оны 06 дугаар сарын 12,13,14-ний өдрүүдэд 3 хоног зохион байгуулж сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвийн их эмч нарыг хамрууллаа.

Сургалтын сургагч багшаар Австрали улсын Бендиго хотын эмнэлгийн яаралтай тусламжийн эмч нар болон ММЭН-ийн гишүүд онол, дадлага хосолсон хэлбэрээр амжилттай зохион байгуулсан.

Сургалтын гол зорилго: Анхан шатны эмч нарын яаралтай, амь нас нь тэнссэн зайлшгүй шаардлагаар хандсан үйлчлүүлэгчийг харьяалал харгалзахгүй хүлээн авч эрэмбэлэн, эмнэлгийн анхны болон амилуулах суурь тусламжийг үзүүлэх мэдлэгийг нэмэх, мэдлэг ур чадварыг дээшлүүлж, чадавхжуулах юм.

Сургалтын зорилт:

- Эмнэлгийн яаралтай тусламжид үйлчлүүлэгчийг зөв эрэмбэлэх
- Насанд хүрэгчдэд амилуулах тусламж, амь тэнссэн үеийн тусламжийг үзүүлэх үндсэн ойлголт, чадвар эзэмшүүлэх багц цагийн сургалт явуулах
  - Насанд хүрэгчдийн амь тэнссэн үеийн үндсэн ойлголттой болох
  - Эрт сэрэмжлүүлэх үнэлгээ
  - Амилуулах тусламж үзүүлэх чадвар эзэмших
  - Амь тэнссэн үеийн багийн тусламжийг үзүүлэх чадвар дээшлэх.
  - Амь тэнссэн үед хэрэглэгдэх багаж тоног төхөөрөмжийг хэрэглэх чадвар дадал эзэмших

Сургалтын үр дүн анхан шатны эмнэлгийн эмч нар яаралтай тусламжийн мэдлэгээ дээшлүүлж, анхны тусламж, амилуулах суурь тусламж үзүүлэх ур чадвар нэмэгдэх юм.

Эрүүл мэндийг газрын Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтсийн дарга, ахлах нягтлан бодогчийн бүрэлдэхүүнтэй Алтанбулаг ЭМТөв, Түшиг ЭМТөв, Ерөө

ЭМТөв, Шаамар ЭМТөвд ажиллаа. Үүгээр 2022 оны санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтээр “Хязгаарлалттай” дүгнэгдсэн тул цаашид алдаа оноогүй ажиллах, анхан шатны маягтын хөтлөлт, шилэн дансны мэдээлэлд дүгнэлт өгч зөвлөн тусалж хамтран ажиллалаа.

Аймгийн Засаг даргын удирдамжийн дагуу төр хувийн хэвшлийн байгууллагын алба хаагч, ажилтан нарт “БЗДХ-ын өнөөгийн байдал, урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл өгөх, мэдлэг хандлага өөрчлөх” сэдэвт сургалтыг нийт 11 байгууллагын 419 иргэнд мэдээллийг хүргэн ажиллалаа.

Мөн Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/188 тоот тушаалын дагуу 10 сартайгаас 8 нас хүртэлх хүүхдүүдийг улаанбурхан, улаануудын нэмэлт дархлаажуулалтанд хамруулахаар товлож, орон даяар 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн дархлаажуулж эхэлсэн. **Өнөөдрийн байдлаар аймгийн хэмжээнд 13275 хүүхэд хамрагдсан.**

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 05 дугаар сарын 01-ээс хэрэгжүүлж эхэлсэн “Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоо шинжилгээнд хагас жилийн байдлаар 2585 иргэн хамрагдсан. Үүнээс 0-17 насны хүүхэд 93, 18-30 насны иргэн 233, 31-45 насны хүүхэд 840, 46-60 насны иргэн 1007, 61-ээс дээш насны 412 иргэн тус тус хамрагдсан байна

**Хөдөлмөр, халамжийн чиглэлээр:** Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж хөнгөлөлтийн үйлчилгээг зорилтот бүлэгт түргэн шуурхай, хүнд сурталгүй чанартай хүргэх ажлын хүрээнд:

Улсын төсвийн орлогоос:

Халамжийн санд улсын төсвөөс тайлант хугацаанд 66681 иргэнд 31188082.5 мянган төгрөгийг олгоод байна.

Үүнд:

- Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2327 иргэнд 3777965.6 мянган төгрөг
- Нийгмийн халамжийн тэтгэмжид 1778 иргэнд 924028.3 мянган төгрөг
- Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмжид 1651 иргэнд 733666.1 мянган төгрөг
- Жирэмсэн эхийн тэтгэмжид 727 эхэд 148542.5 мянган төгрөг
- 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж 4218 эхэд 1178704.8 мянган төгрөг
- Ихэр хүүхдийн тэтгэмжид 8 иргэнд 16000.0 мянган төгрөг
- Өрх толгойлсон эхийн тэтгэмжид 225 иргэнд 243972.9 мянган төгрөг
- Ахмад настанд олгох хөнгөлөлт, тусламжинд 2430 ахмадын 204813.5 мянган төгрөг
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх хөнгөлөлт, тусламжинд 282 иргэний 86996.8 мянган төгрөг
- Алдар цолтон ахмад настанд олгох хөнгөлөлт, тусламжид 48 иргэнд 8028.1 мянган төгрөг
- Насны хишиг тэтгэмжид 5750 иргэнд 889320.0 мянган төгрөг
- Эхийн алдар одонгийн тэтгэмжид 9332 иргэнд 1242300.0 мянган төгрөг
- Хүнсний эрхийн бичгийн 1790 иргэнд 118144.0 мянган төгрөг
- Хүүхдийн мөнгөн тэтгэмжид 36115 иргэнд 21615600.0 мянган төгрөгийг тус тус зарцууллаа.

Орон нутгийн төсвийн орлогоос:

Халамжийн санд орон нутгийн төсвөөс тайлант хугацаанд 299 иргэнд 82172.0 мянган төгрөгийг олгоод байна. Үүнд:

- Орон гэрийн хөнгөлөлт, тусламжид 21 иргэнд 25200.0 мянган төгрөг
- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 103 иргэнд 50900.0 мянган
- Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшуулалд 175 иргэнд 6072.0 мянгантөгрөгийг тус тус зарцууллаа.

#### Хөдөлмөр эрхлэлт:

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэхээр дараах үйлчилгээг иргэдэд үзүүллээ. Үүнд:

- Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан EJOB програмд баяжилт хийж:
  - Ажил олгогчийн мэдээлэл - 106
  - Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд 202 иргэн
  - Идэвхтэй ажил хайгчаар – 254 иргэн
  - Ажил зуучлах үйлчилгээнд – 193 иргэн
  - Сул чөлөөтэй 69 ажлын байр
  - Шинээр бий болсон 429 ажлын байрыг бүртгэж мэдээлсэн байна.

05 дугаар сарын 30-ны өдөр "АЖЛЫН БАЙРНЫ ӨДӨРЛӨГ", үзэсгэлэн худалдааг Баянгол сумын Соёлын төвд зохион байгуулж "БОРОО ГОУЛД" ХХК, "Шанхай констракшн" ХХК, "Жун мэй инженеринг" ХХК зэрэг ажил олгогч байгууллагаас ирүүлсэн 30 ажлын байрыг иргэдэд нээлттэй мэдээлж, 60 гаруй ажил хайгч иргэн ажил олгогчтой уулзалт ярилцлагад орж, мэдээлэл зөвлөгөө авснаас 18 иргэн ажлын байранд зуучлагдсан байна.

Хөдөлмөрийн зах зээлийн болон ажил олгогчийн эрэлтэд нийцүүлэн иргэний суралцах мэргэжлийн чиглэл, боломжийн талаарх хүсэлтэд үндэслэн мэргэжлийн ур чадварыг богино хугацаанд эзэмшүүлэх хөдөлмөр эрхлэлтийн танхимын сургалтад ажилгүй, ажил олоход хүндрэлтэй болон нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай Мандал сумын 20 иргэнд гоо засалч, Сүхбаатар сумын 20 иргэнд оёдол, 20 иргэнд фермерийн аж ахуй эрхлэгч, 20 иргэнд бэлэг дурсгалын зүйл урлаач, нийт 80 иргэнийг танхимын мэргэжил олгох сургалтад хамруулж, Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас 20060.0 мянган төгрөгийг зарцууллаа.

Сүхбаатар, Мандал, Баянгол, Алтанбулаг, Сант, Сайхан сумдад ажлын байр түрээслэн хувиараа хөдөлмөр эрхэлж буй ХЭДСангаас санхүүгийн дэмжлэг авсан 6 иргэнд 5400.0 мянган төгрөгийн түрээсийн дэмжлэг олголоо.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр орон нутгаас санхүүжүүлж буй "СЭЛЭНГЭ-СТАРТ-АП" арга хэмжээг "Бэст метод" ХХК-тай хамтран 2023 оны 05 сарын 24-26-ны өдрүүдэд залуучуудын бүтээлч санаа, санаачлага, гарааны бизнесийн хөгжүүлэлтийг дэмжин ажиллах чиглэлээр 3 хоногийн сургалт зохион байгууллаа. Сэлэнгэ старт ап хөтөлбөрт 11 сумын 21 бүлгийн 44 залуучууд оролцохоор төсөл ирүүлснээс 2 залуучуудын бүлэг шалгарч, дээрх залуучуудын бүлэгт тус бүр эргэн төлөх нөхцөлгүй 10000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгох гэрээ байгуулаад байна. Шилдэг бүлгээр 2 бүлэг шалгарсан бөгөөд 1-р байранд Мандал сумын "Соосой гутлын брэнд", 2-р байр Баянгол сумын "Амуу бэйкери" бүлэг тус тус шалгарлаа.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны түрээсийн хөнгөлөлтөд Алтанбулаг, Сайхан, Сант, Орхон сумын 4 ХБ-тэй иргэн хамрагдаж ХЭДС-аас 3280.0 мянган төгрөгийн дэмжлэг олгосон.

Танхимын мэргэжил олгох бэлэг дурсгал урлаач /гар урлал/-ын сургалтыг Монголын удирдлага, шинэчлэл менежментийн академийн дэргэдэх “Сонор” сургалтын төвтэй хамтран зохион байгуулж 14 иргэн хамрагдаж ХЭДС-аас 4212.0 мянган төгрөг зарцуулсан.

Түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагаанд ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ арга хэмжээнд 10 ахмад настан боловсрол, эрүүл мэнд, төрийн захиргаа, нийгмийн хамгаалал, мал эмнэлэгийн салбарт зөвлөх үйлчилгээ үзүүлж 9900.0 мянган төгрөгийн урамшуулал ХЭДС-аас зарцуулсан байна.

Мандал, Баянгол, Хушаат, Сайхан, Ерөө, Хүдэр, Сант, Номгон, Рашаант, Дулаанхаан, Зүүнбүрэн, Орхон зэрэг сум тосгод мод тарих арга хэмжээг зохион байгуулж нийтийн эзэмшлийн гудамж талбай болон ойд нөхөн сэргээлт ойжуулалт хийж ажил олоход хүндрэлтэй болон ажилгүй 110 иргэнийг түр ажлын байраар хангаж ХЭДС-аас ажлын урамшуулал болон ХАБЭА-н зардалд 25940.0 мянган төгрөг олгосон.

Алтанбулаг, Дулаанхаан, Номгон, Сүхбаатар, Хүдэр, Орхон зэрэг сум тосгодод үерийн далан сэргээн засварлах, нийтийн эзэмшлийн талбай цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт, хашаажуулалт, зам засварын нийтийг хамарсан ажилд 75 иргэн хамрагдаж цалин урамшуулал, ХАБЭА-н зардалд 16478.0 мянган төгрөг зарцууллаа

#### **Гэр бүл, хүүхэд залуучуудын чиглэлээр:**

Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг “НЭГДҮГЭЭРТ ХҮҮХЭД” уриан дор 17 сум, 6 тосгонд 7 чиглэлийн хүрээнд тэмдэглэн өнгөрүүллээ. Мөн OPEN MIC арга хэмжээг залуучуудын дунд зохион байгуулж, 68 залуучууд оролцож авьяас чадвараа үзүүллээ.

Орон нутгийн цахим хуудсаар дамжуулан “Гэр бүлийн үнэ цэнэ”, “Хүүхдийн хайр”, “Хүүхдийн эрх”, “Хүүхдийн тусламжийн 108 утас”, богино хэмжээний видео шторк, Өөр шигээ хүндэлье уриатай “Найз байя” үндэсний аяны 12 төрлийн видео контент, 5 төрлийн постерыг байршуулж 236 хүн хуваалцаж, хандалт 4589 хүн үзсэн байна.

Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг дэлхийн өдрийг тохиолдуулан “Нийгмийн шудрага ёсыг бэхжүүлэе”, “Хүүхдийн хөдөлмөрийг устгая” уриан дор зөвлөгөөн зохион байгуулж цахим /Live/ хэлбэрээр иргэд, олон нийтэд түгээсэн.

Мөн нөлөөллийн үйл ажиллагааны постер-2, видео-1 төрлийг байгууллагын албан ёсны Вэб сайт, пэйж хуудсаар дамжуулан мөн 17 сум, 6 тосгоны орон нутгийн пэйж сайтаар олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулсан.

Мандал сумын Түнхэл тосгоны Батлан хамгаалах яамны харьяа “Шонхор” зуслан 7 ээлжээр “Цэрэгжилт” хөтөлбөрийн дагуу үйл ажиллагааг эхлүүлж, 3 дахь ээлжинд 80 хүүхдийн хамруулж, MNS:56332019 стандартын хэрэгжилтийг ханган ажиллаж байна

“Тэгш боломжийн төлөө залуусын манлайлал” сургалтыг Хилийн цэргийн 0101, 0243 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагч, Хүдэр сумын Эрүүл мэндийн төвийн ажилтнууд, Хөдөө аж ахуйн газрын алба хаагч болон иргэдийн төлөөлөл 15-34 насны 185 залуучуудад зохион байгууллаа.

“Тэгш оролцоо-2023” хүүхдийн зуслангийн төвийн бүсийн чуулган Дархан-Уул аймгийн “Зулзагын гол” зусланд зохион байгуулагдсан. Энэ удаагийн хөтөлбөрт аймгаас төлөөлж 60 хүүхэд оролцсон. Хүүхдүүд маань 4 өдрийн зуслангийн хөтөлбөрөөр "Сайн байна уу зуслан минь", "Хамтдаа бүтээцгээе", "Хүүхдийн зөвлөл", "Монгол бахархал", "Баяртай зуслан минь" зэрэг хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд бүлэгт хуваагдан багаар ажиллах, өөрийгөө танин мэдэх, бусдыг хүндэтгэх, байгаль, эх орноо хайрлахад суралцахаас гадна шинэ найз нөхөдтэй болж, цагийг бүтээлч, хөгжилтэй өнгөрүүлээ.

“Өнөр бүл”, “Мана” хүүхдийн халамж асрамжийн төвд амьдарч байгаа Сэлэнгэ аймгийн харьяат 2 хүүхдийг эргэж, хүүхдүүдийн байгаа орчин нөхцөлтэй нь танилцсан. Хүүхдүүдийг эргэх үйл ажиллагааг зохион байгуулснаар “Өнөр бүл” төвд байгаа А-г 21 нас хүртэл, “Мана” асрамжийн төвд байгаа О-г 6 нас хүртэл нь үргэлжлүүлэн асрамжлуулахаар шийдвэрлэн ажиллалаа.

### **Нийгмийн даатгалын чиглэлээр:**

2023 оны 06 дугаар сард Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь Улсын Нийгмийн даатгалын Ерөнхий газраас 2,500.0 саятөгрөгийн санхүүжилт хүлээн авсан.

Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 29,677,360.00 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл оруулах төлөвлөгөөтэйгөөс 1-р улирлын гүйцэтгэлээр 35,544,300.00 мянган төгрөг хуримтлуулж төлөвлөгөөний биелэлт 98,63 хувьтай байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 18845 тэтгэвэр авагчдад 63,371,990.000 мянган төгрөгийг олголоо.

Тэтгэмжийн даатгалын сангаас ХЧТА 2442 хүнд 887,020.00 жирэмсэн болон амаржсаны 586 хүнд 2,323,470.00, оршуулгын 195 хүнд 508,660.00 мянган төгрөгийн тэтгэмж олгожээ.

ҮОМШӨ-ний даатгалын сангаас 168 даатгуулагчид 585,850.00 мянган төгрөгийн тэтгэвэр, ҮО-ийн тэтгэмж, сувиллын зардалд олгосон.

Ажилгүйдлийн даатгалын сангаас 312 даатгуулагчдад 1,301,840.00 мянган төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг хугацаанд нь олгож ажилласан олгосон

Нийт 21 аймаг, 9 дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдээс 1995-2005 оны 139 лавлагааны хүсэлтийг цахимаар хүлээн авч 134 лавлагааг гарган хугацаанд хүргүүллээ. Мөн аймгийн 17 сумын 255 иргэд даатгуулагчаас лавлагааны хүсэлтийг авч нийт 252 лавлагааг хугацаанд гаргаж ажиллаа.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс нь энэ 06 сард суурин 4 удаа хуралдаж нийт 300 иргэн даатгуулагчид эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйлчилгээ үзүүлж 20 иргэнд шинээр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаа тогтоож 265 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг сунгаж 89 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ хугацааг цуцалсан байна.

НДЕГ-ын дотоод хяналт шалгалтаар 2018-2022 оны дуусталх хугацааны санхүүгийн болон тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн зарцуулалт, бусад холбоотой баримт бичгийг 14 хоногийн турш шалгуулан дүнгийн хурлаа хийж урьдчилсан дүнгээр сайн үнэлэгдсэн.

Монгол улс Төрийн албаны зөвлөлийн даргын 2023.05.31-ний өдрийн 81 тоот тушаалын удирдамжийн дагуу 2023.06.12-2023.06.14-ний өдрүүдэд үргэлжилсэн шалгалтад зөрчилгүй хамрагдсан.

Сэлэнгэ аймгийн 19037 иргэний тэтгэврийн итгэлцүүр өөрчлөгдөж, нэг бүрчлэн засварлан, 4800 иргэний тогтоолтын хуудас хэвлэсэн.

### **Биеийн тамир, спортын чиглэлээр:**

“Сэлэнгэ Марафон-2023” гүйлтийн тэмцээн 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулагдаж, тэмцээнд Сэлэнгэ аймгийн 14 сум, тосгод, 10 аймаг /Дархан, Орхон, Говьалтай, Хэнтий, Дорнод, Төв, Булган, Баянөлгий, Сүхбаатар, Сэлэнгэ/, 7 дүүрэг болон Япон, Хятад Улсын элчин сайдын яамны төлөөлөгчидийн нийт 560 гаруй тамирчид оролцлоо.

Монголын Хүүхдийн спортын зуны 7-р наадам Баянхонгор аймагт 2023 оны 6 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн 10 өдрийн турш амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Тус наадамд манай аймгаас 236 тамирчин, 39 багш дасгалжуулагчийн хамт оролцож 21 аймгаа тэргүүлсэн амжилтыг үзүүлсэн.

Наадмын хүрээнд зохион байгуулагдсан 23 спортын төрлөөс 19 төрөлд нь оролцож, 13 алт, 11 мөнгө, 11 хүрэл нийт 35 медалийн эзэд болцгоосон.

### **Соёл урлагын чиглэлээр:**

Соёлын сэргэлт-2023 аян Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суманд 6 дугаар сарын 5-ны өдөр нээлтээ хийж 17 сум 6 тосгонд ажиллах хуваарийн дагуу соёл урлагийн байгууллагууддаа түшиглэн явуулж байна. Байгалын түүхийн музей, Соёл урлагийн газрын нийт 12 хүний бүрэлдэхүүнтэй баг хөтөлбөрийн дагуу ажиллаж 6 дугаар сарын 27-ны өдөр Мандал суманд хаалтын үйл ажиллагаа хийгдэнэ.

### **Тав. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хүрээнд:**

**Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр:** Аймгийн Засаг даргын 2023 оны А/278 тоот захирамжаар Тариалангийн бүс болох Сэлэнгэ аймгийн 17 сумын нутагт үржүүлж буй үржлийн малд үзлэг ангилалт хийх, цөм сүрэг бүрдүүлэх, баталгаажуулах, стандартын шаардлага хангасан үржлийн малыг цөм сүргээр баталгаажуулж эзэмлэж, бүртгэлжүүлэх ажлыг орон нутгийн төсвөөр хийж гүйцэтгэхийг сумдад үүрэг болгон хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд 719.1 мянган толгой мал төллөж гарсан төлөөс 33.0 мянга толгой төл хорогдож, мал төллөлт 81,8 хувьтай, төл бойжилт 95,4 хувьтай, оны эхний нийт сүргээс 30.1 мянган толгой том мал зүй бусаар хорогдоод байна.

Хаврынүзлэг ангилалтанд 42.8 мянган толгой хонинд үзлэг хийж, малын үндсэн үзүүлэлтүүд сэрвээ, хондлойн өндөр, биеийн ташуу урт, шилбэний бүслүүр, бүсэлхийн тойрог, цээжний гүн, өргөн, амьдын жингийн хэмжээг авч, цөм сүргээр баталгаажуулан өсвөр хээлтүүлэгчийг эзэмлэж, бүртгэлжүүлэх ажлыг хийсэн.

Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн яамны харъяа судалгаа хөгжлийн төвтэй хамтран “Зөгийн аж ахуй эрхлэгчдийн зориулан зөгийн балны мөшгих систем нэвтрүүлэх сургалт”-ыг Шаамар суманд зохион байгуулж, Шаамар, Зүүнбүрэн, Цагааннуур, Сүхбаатар, Сант, Сайхан сумдын зөгийн аж ахуй эрхлэгч 120 гаруй төлөөллийг оролцууллаа.

Сэлэнгэ аймаг Япон улсын Шизуока муж хоорондын хамтын ажиллагааны хүрээнд Алтанбулаг, Ерөө, Зүүнбүрэн, Орхон, Сайхан, Шаамар сумдад “Газар тариалангийн сургалт”-ыг зохион байгуулж, Японы Шизуока мужийн газар тариалан, цаг уурын хувьд бүс нутгийн төстэй хугацаа, бордоо хийх, хүлэмжний ногоо тариалахад анхаарах асуудлын талаар танхимын болон практик сургалтыг амжилттай зохион байгууллаа.

**Мал эмнэлгийн чиглэлээр:** Мал Эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2023 оны А/19, А/34, А/87 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2023 оны А/165, А/214, А/303 дугаар захирамжийн дагуу аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 1.1 сая толгой мал, амьтан хамрагдахаас технологит хугацаанд 569.0 мянган толгой мал, амьтан хамрагдаж 50.3 хувьтай, 6.7 мянган ширхэг малын хашаа, байрны 973.8 мянган м<sup>2</sup>, 47 ширхэг гахайн байрны 65.1 мянган м<sup>2</sup>, 72 ширхэг шувууны байрны 9.5 м<sup>2</sup>, 399 ширхэг тээврийн хэрэгслийн 76.5 мянган м<sup>2</sup>, 1045 ширхэг тоног хэрэгслийн 25.8 мянган м<sup>2</sup>, 2.3 мянган ширхэг зоорины 17.2 мянган м<sup>2</sup>, 63 ш тэжээлийн агуулахын 37.1 мянган м<sup>2</sup>, 58 ш худаг, уст цэгийн 34500 м<sup>2</sup>, 684 тн өтөг бууцны 606.8 мянган м<sup>2</sup>, бэлчээрийн талбай 252.4 мянган, 41 түүхий эд, бүтээгдэхүүн хадгалах цэгийн 40.3 мянган м<sup>2</sup>, голомт болон устгалын цэгийн 286.9 мянган м<sup>2</sup>, 588 ш нийтийн эзэмшлийн объект, зам талбайн 272.1 мянган м<sup>2</sup> буюу нийт 2.6 сая м<sup>2</sup> талбайд тус тус ариутгал халдваргүйтгэлийг хийж, 9.7 мянган ширхэг сэг зэмийг цуглуулж зориулалтын цэгт устгасан.

Зүүнбүрэн сумын нутаг дэвсгэрт 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдөр Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумаас “Гацуурт” ХХК-ийн туувраар оруулж ирсэн мал эмнэлгийн гэрчилгээгүй 323 толгой адууг сумын нутаг дэвсгэрээс албадан гаргах чиглэлээр аймаг, сумын нийт 5 мэргэжилтэн газар дээр нь очиж ажиллаж, аймгийн нутаг дэвсгэрээр тууварлах шилжилт хөдөлгөөн хийх чиглэл, нутаг дэвсгэрийг тухайн нутаг дэвсгэр дэх мал, амьтны гоц халдварт, халдварт болон шимэгчтэх өвчний тархвар зүйн судалгаанд үндэслэн маршрутын зураглалыг гарган хүргүүлж, мал эмнэлгийн гэрчилгээгүй оруулж ирсэн, мал амьтны эзэнд зөрчлийн хэрэг нээж хариуцлага хүлээлгэхээр ажиллаж байна.

Мал эмнэлгийн улсын байцаагч, тархвар зүйч нарын хууль эрх зүйн мэдлэг, ур чадварыг сайжруулах зорилгоор Мал эмнэлгийн ерөнхий газраас зохион байгуулсан “Зөрчил шалган шийдвэрлэх нь” сэдэвт сургалт зохион байгуулж нийт сумдын Малын эрүүл мэндийн төвийн мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч, тархвар зүйч, мал эмнэлгийн газрын мэргэжилтэн нийт 27 хүн хамруулан зохион байгуулсан.

Сүхбаатар сумын хэмжээнд хүнсний зах дэлгүүрт худалдан борлуулж байгаа мах махан бүтээгдэхүүний 5640 кг үхрийн махны 47 дээж, 450 кг адууны 5 дээж, 609 кг хонины махны 29 дээж, 540кг ямааны махны 27 дээж, 50ш үхрийн шир, 140кг сүү, сүүн бүтээгдэхүүний 7 дээж ариун цэврийн магадлан шинжилгээг стандарт арга зүйн дагуу хийж гүйцэтгэсэн.

Зүүнбүрэн, Хүдэр, Сүхбаатар, Хушаат, Мандал, Цагааннуур, Ерөө сумаас 112 арчдасны дээж, Зүүнбүрэн, Хүдэр, Сүхбаатар, Хушаат, Мандал, Цагааннуур, Ерөө сумын 2141 дээжинд ийлдэс судлалын шинжилгээг хийж, Хүдэр сумын 1 адууны дээжинд АХЦБӨ-ний эсрэгбием илэрч хариуг баталгаажуулсан.

Зүүнбүрэн, Хүдэр, Сүхбаатар, Хушаат, Мандал, Цагааннуур, Ерөө сумын 179 дээжинд шимэгч судлалын шинжилгээ хийж гүйцэтгэсэн.

Преми-тестийг ашиглан антибиотикийн үлдэгдэл тодорхойлох шинжилгээг хүнс болон тэжээлд антибиотикийн үлдэгдлийг илрүүлэх арга MNS 6665:2017 стандартын дагуу 6 сорьц дээж цуглуулан Ampicillin, Penicillin, Chloramphenicol, бүлгийн антибиотик байгааг илрүүлэх шинжилгээг хийж, уг бүлгийн антибиотикүүд зөвшөөрөгдөх хэмжээнээс бага буюу сөрөг дүнтэй байгааг тогтоосон.

Улсын мэл эмнэлэг ариун цэврийн төв лобароторийн А/34 дугаар тушаалаар гоц халдварт шүлхий өвчний вакцин мониторингийн тандалтын ажлыг зохион байгуулахаар удирдамж боловсруулан баталж сумд руу албан тоотоор хүргүүлэн ажиллаж байна.

Мал эмнэлгийн лабораторийн цахим систем /vetlab.shinjilgee.mn/-д 111 хандалтын 227 сорьц дээжийг бүртгэсэн байна.

**Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр:** Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Хаврын бүх нийтээр мод тарих” ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, 17 сум, 6 тосгоны 2410 иргэн, 287 аж ахуйн нэгж, байгууллага мод тарих ажилд оролцож 7043 м<sup>2</sup> цэцгийн мандал, 4012м<sup>2</sup> талбайд зүлэгжүүлэлт, 5,5 га талбайд цэцэрлэгт хүрээлэн, 6 нэрэмжит төгөл байгуулж ойжуулалтыг ажлыг 320 га талбайд 777.3 мянган ширхэг тарьц, ойн зурвас 25 га талбайд 14.0 мянган ширхэг суулгацаар хийж, нийт 1.4 сая ширхэг модыг 1,1 тэрбум төгрөгийн зардал гарган тарьсан.

Япон Улсын Шүзүока мужийн төлөөлөгчдийг хүлээн авч Алтанбулаг, Шаамар сумдын мод үржүүлгийн үйл ажиллагаатай танилцуулж, “Япон, Монгол орны ойн сангийн өнөөгийн байдал, мод үржүүлгийн газрын үйл ажиллагааны талаар”, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг орон нутагт хэрхэн зохион байгуулах сургалт”-ыг зохион байгуулж Алтанбулаг, Сүхбаатар, Шаамар сумдын 50 гаруй иргэнийг хамрууллаа.

“Ногоон хэрэм” төслийн хүрээнд хэрэгжүүлж буй ажил, үйл ажиллагаатай нь танилцаж, төслийн багийнхан Бугант тосгонд 15 га талбайн мод үржүүлгийн газарт 5 төрлийн шилмүүст модны үр 100 мянган ширхэг бургасны мөчир тарьж арчилж байна.

“Stream”төслийн багийнхан Жавхлант суманд 1 га талбайд мод үржүүлгийн газар байгуулж голт бор, бургас, шар хуайс зэрэг модны үр, мөчрийг тарихад мэргэжил арга зүйгээр хангаж хамтран ажиллалаа.

2023 оны байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар шууд гэрээ байгуулан гүйцэтгэх “Биотехникийн арга хэмжээ”, “Байгалийн ховор ургамлыг тарималжуулах”, Хил дамнасан түймрээс хамгаалах 118 км шорооны зурвасны арчилгааны ажлуудыг хүлээн авсан.

Аймгийн хэмжээнд усны тоо бүртгэл болон хамгаалалтын бүсийг тогтоох ажил хийгдэж байна. Орхон-Чулуут, Сэлэнгэ, Хараа-Ерөө голын сав газруудын захиргаатай хамтран зохион байгуулж байна. Орхон, Сайхан суманд байгуулсан хамгаалалтын ойн зурвас байгуулсан талбайн усалгааны асуудлыг шийдвэрлэх ажлыг “Сэлэнгэ Ундрам” ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна.

**Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын чиглэлээр:** Засгийн газрын 2021 оны 213 дугаар тогтоол, Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрмийн дагуу 37 ажилд барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон байна.

“Таван хан гранд эрдэнэс” ХХК, “Тэнгис жааз майнинг” ХХК, “Булган инвэст” ХХК, “Монгол алт” ХК-уудын түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл авахаар өргөдөл гаргасан байршил нь “Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 194 дүгээр тогтоолоор батлагдсан “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газрын хил зааг”, 2015 оны 289 дүгээр тогтоолоор батлагдсан усны сан бүхий газрын хамгаалалттай бүс мөн Байгаль орчин аялал жуулчлалын яамны ой, ус, тусгай хамгаалалттай газрын мэдээллийн сантай давхцалтай эсэхийг тогтоонхолбогдох газарт хүргүүлсэн.

Ерөө, Жавхлант сумдын сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлыг “Ланд овнер” ХХК нь 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр тус сумдын төлөвлөгөөг Иргэдийн Хурлын Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлсэн.



Баруунбүрэн, Сант сумдын хилийн цэсийн маргааныг шийдвэрлэхээр газар дээр нь ажиллаж хээрийн хэмжилт тодруулалтыг хийж гүйцэтгэлээ.

Аймгийн хэмжээнд ашиглагдаж байгаа хог хаягдлын төвлөрсөн цэгүүдийн мэдээлэл болон шинээр байгуулах шаардлагатай хог хаягдлын төвлөрсөн цэгийн мэдээлэл, ойн сан бүхий газар, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд эзэмшил, ашиглалтад олгогдсон газрын судалгааг гаргаж хүргүүлсэн.

Сүхбаатар сумын инженерийн шугам сүлжээтэй газарт нийт 56 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэж ажиллалаа.

Хот байгуулалтын мэдээллийн сангийн шинэчилсэн програм хангамж болон архитектур төлөвлөлтийн даалгавар, барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад хүлээн авах зөвшөөрлийг цахимаар нийт 8 хүсэлт ирснээс архитектор төлөвлөлтийн даалгавар батлагдсан 4, эх загвар зураг /эскиз/ батлагдсан 4 хүсэлт байна.

Урбан менежер цахим мэдээллийн санд 17 сум, 6 тосгоны нийт 1520 барилга байгууламж бүртгэгдсэн. Хот байгуулалтын кадастрын системийн өгөгдлийг шинэчлэх, баяжуулах ажлын хүрээнд Хүдэр, Сант, Алтанбулаг, Сайхан, Ерөө сумын нийт 21 барилга нэмж бүртгэх боломжтой судалгааг гаргасан.

Хот байгуулалтын кадастрын цахим системээс архитектур төлөвлөлтийн даалгавар, барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл болон барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлтийг цахим системээр олгоогүй нөхөж бүртгэх ажлын хүрээнд 1 сумын 5 барилгын мэдээллийг цуглуулан ажиллалаа.

**Хяналт шалгалтын ажлын хүрээнд:**Харьяа яамдын Салбарын хяналтын газруудаас батлагдан ирсэн төлөвлөгөөт хяналт шалгалтыг удирдамжийн хүрээнд 20 аж ахуй нэгж байгууллагад хийж, 19 аж ахуй нэгжид 149 заалт бүхий улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлж, хууль зөрчиж үйл ажиллагаа явуулж байсан 1 аж ахуй нэгжийн үйл ажиллагааг улсын байцаагчийн актаар түр зогсоох арга хэмжээ авч илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахад хяналт тавин ажиллаж байна.

Салбарын хяналтын газруудаас ирсэн төлөвлөгөөт бус шалгалтыг удирдамжийн дагуу төрийн байгууллага болон бусад аж ахуй нэгж байгууллагаас ирүүлсэн чиглэл, албан хүсэлтийг үндэслэн 42 аж ахуй нэгжид шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар 9 аж ахуй нэгжид 54 заалттай хугацаатай албан шаардлага хүргүүлж, 1 аж ахуй нэгжид улсын байцаагчийн дүгнэлтийг гаргаж хүргүүлсэн.

Салбарын хяналтын газруудаас ирүүлсэн 2023 онд хийгдэх урьдчилан сэргийлэх хяналтын чиглэлээр болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөрчил, дутагдал, хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох зорилгоор 5 хяналтын чиглэлээр 26 аж ахуй нэгжид урьдчилан сэргийлэх шалгалтыг зохион байгуулж 13 аж ахуй нэгжид 74 заалттай улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага, 3 аж ахуй нэгжид 12 заалттай зөвлөмжийг хүргүүлэн биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.

### **Зургаа. Сүм орон нутгийн ажил үйлчилгээний талаар:**

#### **Алтанбулаг сүм:**

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4.1.6-дэхь заалт “Хүүхдийн баяр буюу 6 дугаар сарын 1” –ний өдрийг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17.1.2, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9.1, 9.2 дахь заалтыг үндэслэн сумын Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн “Нэгдүгээрт

хүүхэд” хүүхдийн баярын арга хэмжээг зохион байгууллаа. Арга хэмжээний хүрээнд дараах ажлууд хийгдлээ. Үүнд:

-5 төрлийн киног үнэ төлбөргүйгээр давхардсан тоогоор 560 хүүхэд үзсэн.

-Сумын засаг даргын нэрэмжит сагсан бөмбөгийн тэмцээн спорт цогцолборт зохион байгуулагдаж байна. Сагсан бөмбөгийн тэмцээнд 10-12 дугаар ангийн 11 багийн 70 өсвөр залуу үеийн тамирчид сурагчид өрсөлдөж, тэмцээнд амжилттай оролцсон баг тамирчдад алт мөнгө хүрэл медаль, мөнгөн шагналааршагналаа.

-“Бид үлгэрийн баатруудын дүрээр” жүжигчилсэн дүрийн тоглолт (сургуулийн өмнөх боловсролын бэлтгэл бүлгийн 26 хүүхэд),

-Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар “Алдарт эх”-ийн 1 дүгээр одон -2, “Алдарт эх”-ийн 2 дугаар одонг 7 ээжид гардуулсан.

-“Медалиа зүүцгээе” улс, аймгийн олимдиадад амжилт гаргасан урлаг, спортын шилдэг 115 хүүхдийг алдаршуулсан.

-7 хүүхдэд сумын Засаг дарга гарын бэлгээ гардуулсан.

-Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга “Ногоон гэрэл цагаан шугам” тэмцээнд оролцсон 30 хүүхдэд бэлэг гардуулсан.

Бүх нийтийн хог цэвэрлэгээний ажил: Ерөнхий Боловсролын сургуулийн 16 бүлгийн 422 сурагчид, 22 багш ажилтан, сумын Засаг даргын Тамгын газрын 20 албан хаагч, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 13 төлөөлөгч, Найрамдал 1 дүгээр цэцэрлэгийн 23 багш ажилтан, Дамбо 2 дугаар цэцэрлэгийн 25 багш ажилтан, 3 дугаар цэцэрлэгийн 13 багш ажилтан, Спорт цогцолборын 4 ажилтан, Соёлын төвийн 5 ажилтан, сумын Эрүүл мэндийн төвийн 10 ажилтан, Бүргэдэй 1 дүгээр багийн 30 иргэн, Суварга 2 дугаар багийн 13 иргэн, Цөх 3 дугаар багийн 40 иргэн бүгд 9 байгууллага 3 багийн 640 иргэн хамрагдаж бүх нийтийн цэвэрлэгээний ажил зохион байгууллаа.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газрын ажлын хэсэгтэй сумын хэмжээнд мод үржүүлэгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 5 аж ахуйн нэгжийн талбайд хэмжилт тооллого хийсэн.

“Өргөн Сэлэнгэ” ХХК нь 2023 оны хэрэглээний модны хуваарийн дагуу хийгдэх 84 га ойжуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Нийт сумын хэмжээнд 87.5 га буюу 218.750 ширхэг нарсны суулгацаар ойжуулсан. Нийт сумын хэмжээнд 220,843 ширхэг мод бут сөөгийг тарьсан.

#### **Баруунбүрэн сүм:**

Ургацын штабын ажлын хэсэг 06 дугаар сарын 12-ны өдөр сумын хэмжээнд улаан буудай тариалсан аж ахуй нэгж, иргэдийн талбай бүрээр тойрч соёлолтын үзлэг хийхэд сумын дунджаар нийт тариалсан талбайн 7318 га талбай буюу 80 хувь нь сайн, 1830 га талбай буюу 20 хувь нь маш сайн гэсэн үзүүлэлттэй байна. Тариалан эрхэлдэг аж ахуй нэгж, иргэдийн 80 гаруй хувь нь талбайгаа хашаажуулсан. Энэ онд “Норбу агко” ХХК нь 212 га талбайдаа ойн зурвас байгуулан 6200 ширхэг хайлаас модыг талбайгаа тойруулан тарьсан байна.

2023 онд сумын хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 100 үхэрт зохиомол хээлтүүлэг хийлгэхээр малчдаас захиалга авч хүргүүлснээр 06 дугаар сарын 23-ны өдөр зохиомол хээлтүүлгийн техникч ирж ажиллалаа.

2023 онд төлөвлөгөөт 9 төрлийн тарилга төлөвлөгдөж, яаралтай 2 төрлийн дархлаажуулалтын үйл ажиллагаа эхлэн одоогоор мал, амьтны гоц халдварт Шүлхий /A01/ өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад “Бүрэнсүрэг” МЭҮНэгж нь үхэр 14345 толгой, гахай 55 толгой нийт 14400 толгой мал амьтан буюу 100 хувийн гүйцэтгэлтэй, “Батцэнгүүн” МЭҮНэгж нь үхэр 7155 толгой, гахай 45 буюу 100 хувийн гүйцэтгэлтэй, нийт 21600 толгой мал, амьтанд Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт хийгдсэн байна. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан

сэргийлэх тарилгад 119600 толгой бог мал хамрагдахаас “Бүрэнсүрэг” МЭҮНэгж 68500 толгой бог мал хамруулахаас бог 63500 толгой буюу 92.7 хувьтай, “Батцэнгүүн” МЭҮНэгж нь 51000 бог мал хамруулахаас 48200 толгой буюу 94,5 хувьтай технологит хугацаа, хүйтэн хэлхээний горим баримтлан дархлаажуулалтын ажлыг хийж нийт сумын хэмжээнд 111700 толгой бог малд буюу 93,3 хувьтай дархлаажуулалт хийгдэж байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн хөнгөлттэй зээлийн төслийг 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдрөөс 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдөр хүртэл хүлээн авч 06 дугаар сарын 12-ны өдөр төсөл сонгон шалгаруулах хурлаар 2 хоршоо, 1 жижиг дунд үйлдвэрлэгч, 1 иргэний нийт 4 төсөл сонгон шалгаруулж 120 сая.төгрөгийн зээлийг санхүүжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Сумын Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/73 тоот захирамжаар сумын хэмжээнд малын хагас жилийн түүвэр судалгааг амжилттай зохион байгуулж сумын нэгтгэл тайлан мэдээг 06 дугаар сарын 14-ний өдөр аймгийн Статистикийн хэлтэст хүлээлгэн өгсөн.

Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчдын “Эрдмийн баяр”-ын арга хэмжээг 06 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулж, суурь болон төгсөх ангийн суралцагчдын боловсролын гэрчилгээг олгож ажиллалаа. 2022-2023 оны хичээлийн жилд:

- Суурь боловсролд -49
- Бүрэн дунд боловсролд-15 суралцагч төгслөө.

Сургуульд орох насны нийт 54 хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд амжилттай хамруулж төгсгөлөө. Цэцэрлэгийн тайлант өдөрлөгөөр 6 бүлгийн хүүхдүүд 2022-2023 оны хичээлийн жилд сурч мэдсэн зүйлээрээ тайлан тоглолт хийлээ.

2022-2023 оны хичээлийн Үндсэн сургалт хаагдаж, Хувилбарт сургалт эхэлж тус сумын Бургалтай 2 дугаар багийн нутаг Жаргалантад хувилбарт сургалтын үйл ажиллагааг эхлүүлээд байна. Хувилбарт сургалтад 15-20 хүүхдийн хамрагдаж байна.

Дэлхийн гэр бүлийн өдрийг угтан “Хүүдээ, Охиндоо илгээх миний захидал” уралдааныг Ерөнхий боловсролын сургуулийн “Нандин охид”-ын клуб, Монгол хэлний багш Х.Халзбаяртай хамран зохион байгууллаа. Уралдаанд нийт 18 захидал ирж эхний 4 байрыг шагнаж урамшуулж ажиллалаа.

Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг “Нэгдүгээрт хүүхэд” хамтдаа хайрлая, хамгаалая уриан дор тэмдэглэн өнгөрүүллээ. Өдөрлөгөөр Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн сурагчдын дунд “Миний мэдэх дэлхий” гар зургийн уралдаан, 6-12 дугаар ангийн сурагчдын дунд “3х3 сагсанбөмбөг”-ийн тэмцээнийг зохион байгуулан эхний 3 байрыг шагнаж урамшууллаа. Мөн 1-р цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд “Ээжтэйгээ би” хөгжөөнт тэмцээн зохион байгуулж ажилласан.

Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр Алдар эхийн одон гардуулах үйл ажиллагааг зохион байгуулахад Нэгдүгээр одон 1 ээж, Хоёрдугаар одон 12 ээж гардан авлаа. Нийт одон авсан ээжүүдийн бага хүүхдүүдийн дунд “Манцуйтай тамирчин” тэмцээнийг сумын Засаг даргын Тамгын газар, Эмэгтэйчүүдийн холбооноос зохион байгууллаа.

УИХ-ын гишүүн Ч.Ундрамын нэрэмжит “Сэлэнгэ марафон-2023” нээлттэй тэмцээнд 2 дахь жилдээ аймгийн төвд зохион байгуулагдаж тус сумын баг тамирчид багийн дүнгээр 3 дугаар байрт шалгарлаа.

Баруунбүрэн сумын уугуул, Анагаах ухааны доктор, профессор Ш.Болдын санаачилгаар 2023 оны 06 дугаар сарын 07-10-ны өдрүүдэд Улаанбаатар хотоос Уламжлалтын 5 эмч ирж сумын иргэдэд үнэгүй үзлэг оношлогоо хийж, шаардлагатай иргэдэд тан бэлтгэн өгч, бариа засал хийлээ. Тус үзлэг оношлогоонд давхардсан тоогоор нийт 400 иргэн хамрагдлаа.

Товлолын дархлаажуулалтад нийт 46 хүүхэд хамрагдаж, Улаанбурхан улаануудын нэмэлт дархлаажуулалтад 10 сартайгаас 8 нас хүртэлх нийт 575 хүүхэд хамруулаад байна.

Аймгийн хэмжээнд архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг ба түүгээр үйлчилдэг аж ахуй нэгжүүд нь онцгой албан татварын тэмдэггүй болон хуурамч тэмдэг ашиглан татвар төлөхөөс зайлс хийж байж болзошгүй хууль бус үйлдлийг илрүүлэх, чанаргүй хямд стандартын шаардлага хангахгүй архи худалдаалахаас урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчлийг арилгуулах, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх хууль, Татварын ерөнхий хууль, Онцгой албан татварын тухай хууль, Онцгой албан татварын тэмдэгтийн тухай хууль болон бусад хууль тогтоомж тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм журам стандартын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Сэлэнгэ аймгийн Сайхан сумын сум дундын Цагдаагийн хэлтсийн Эрүүгийн хэрэгтэй тэмцэх тасгийн ахмад З.Уранмандал, сумын хэсгийн төлөөлөгч, дэд ахлагч Т.Отгонбаяр нартай хамтран 6 аж ахуйн нэгжийн 1625 ширхэг бараа бүтээгдэхүүнд хяналт шалгалт хийхэд зөрчил илрээгүй.

Сумын нийт малчин болон мал бүхий 28 иргэнд и-баримтын нэвтрэх нэр, нууц үг шинэчилэн өгч 3 багийн 184 иргэнд биеэр болон утсаар холбогдон Татварын ерөнхий хууль, татвар тушаах тайлагнах хугацаа болон холбогдох хууль тогтоомжийн талаар заавар зөвлөгөөг өгч, 2022 оны хөрөнгийн татварын өрийг төлүүлэхээр өрийн ажиллагааг эхлүүлж цахимаар мэдэгдэл хүргүүлэн ажиллаж байна.

Цахим тоон гарын үсгийг 8 иргэнд олгож, нийт өссөн дүнгээр 575 иргэн тоон гарын үсгээ авсан байна.

Төрийн байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд төрийн зарим үйлчилгээг үйлчилгээний нэгдсэн төвөөр дамжуулан операторын горимоор үзүүлэх үйлчилгээг e-mongolia.mn хаягаас нийт 96 иргэн 96 лавлагаа мэдээлэл, e-business.mn хаягнаас 6 аж ахуйн нэгж тоон гарын үсгээр 7 лавлагааг авсан байна. Нийт 29 иргэнд И- монгол апп-ыг хэрхэн хэрэглэх, ашиглах талаар зөвлөгөө мэдээлэл өгсөн. Иргэний улсын бүртгэлийн лавлагаа 31 иргэнд олгосон.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгууль тус сумын 2 дугаар баг, Бургалтай багт зарлагдсаны дагуу 2023 оны 06 дугаар сарын 17,18-ны өдрүүдэд болж өндөрлөлөө.

### **Баянгол сүм:**

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.3 дахь заалт, Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолын дагуу гамшгийн аюулын зарлан мэдээллийн дуут дохио 2023 оны 06 сарын 08-ны өглөө 16 цаг 00 минутад дуугарч талбайн цугларах ажлын хэсэг дараах шуурхай арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Сумын хэмжээнд байрлах нийт 13 аюулгүй цугларах цэгт 66 албан хаагч ажиллаж 2073 иргэн цугларсан.

Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 01/881 тоот албан бичгийн хүрээнд сумын албан ёсны цахим хуудасыг шинэчлэх ажил хийгдэж байна.

Авилгатай тэмцэх газраас “Шүгэл үлээх ажиллагаа”-ны хүрээнд зохион байгуулж буй “Нэгдье”, “Үгүй гэж хэлээд өөрчилье” авилгын эсрэг нөлөөллийн аяныг 2023 оны 05 дугаар сарын 29-ны өдрөөс улс орон даяар өрнүүлж байгаатай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 15-ны 01/1006 тоот албан бичгийн хүрээнд төлөвлөгөө гарган авлигын эсрэг олон нийтийн ёс зүй, ухамсар сэтгэлгээг өөрчлөх сургалтыг албан хаагчдад зохион байгуулж, дэлгүүр худалдааны төв, шатахуун түгээх станц зэрэг газруудад аянд нэгдэхийг уриалж, хэвлэмэл хуудсыг байршуулаад байна.

2023 оны 05 дугаар сарын 24-06 дугаар сарын 09-ний хооронд анги дэвших болон улсын шалтгалт зохион байгуулагдаж суурь боловсрол-111, бүрэн дунд боловсрол-36 суралцагч эзэмшиж гэрчилгээ гардан авлаа.

2023 оны 06 дугаар сарын 15-18-ны өдрүүдэд ЭЕШ-д 12 дугаар ангийн нийт 36 суралцагч хамрагдсан байна.

2023 оны 06 сард сумын татварын орлогын төлөвлөгөө 62206,9 мянган төгрөг батлагдсанаас 28794,6 мянган төгрөг төсөвт төвлөрсөн.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт болон аймгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх нийт 1347,7 сая төгрөгний цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт, гэр хорооллын явган хүний замыг хатуу хучилттай болгох, худаг гаргах, хогны машины мотор хроп авах, цахим худаг засвар, мал ариутгалын дүк машин авах, ковш худалдан авах ажлын үнэлгээний хорооны ажлын хэсгийг тус тус байгуулан тендер шалгаруулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Нийт 152,1 сая төгрөгний санхүүжилтийг олгоод байна. Тусгай зориулалтын шилжүүлгийн болон орон нутгийн төсвөөр санхүүждэг төсвийн байгууллагуудад 1385.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь тогтмол оруулж хэвшсэн ба 28 мэдээ, тайланг шивж оруулсан. Статистикийн үнэ, АҮ-1, худалдаа үйлчилгээ, зоогийн газрын мэдээ, мал эмнэлгийн 4 төрлийн мэдээг хугацаанд нь илгээсэн.

Төсөвт байгууллагын 165 гүйлгээг хянаж, баталгаажуулсан.

Байгаль орчин, газар тариалан, мал аж ахуй, хөдөө аж ахуйн чиглэлээр:

Аймгийн Засаг даргын А/156 дугаарт “Бүх нийтийн хог цэвэрлэгээ зохион байгуулах тухай” захирамжийн хүрээнд 2023 оны 06 дугаар сарын 03-ны өдөр бүх нийтийн хог цэвэрлэгээг сумын хэмжээнд зохион байгуулж төр төсвийн аж ахуй нэгж, байгууллага болон 3 багийн 130 иргэн оролцож 8 тонн хогийг цэвэрлэж төв хогийн цэгт хүргэсэн. Ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх санамж, хуудсыг 80 иргэнд өгч ажилласан. Байгаль орчны хяналт шалгалтыг 8 удаа зохион байгуулсан байна.

2024 нөхөн сэргээлт арга хэмжээний хүрээнд 30 га газарт нөхөн сэргээлтийн ажлыг хийлгэсэн. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 5000 ширхэг модыг Хараа голын дагуу тарьсан.

Сумын Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/121 дугаар захирамжийн дагуу 3 багийн хэмжээнд мал, тэжээвэр амьтдын түүвэр судалгааг 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн 6 дугаар сарын 06-ны өдөр хүртэлх хугацаанд хийж, сонгогдсон Хараа баг 57 өрх, Баян баг 57 өрх, Гонир баг 45 өрх, нийт 159 өрхийн мэдээллийг программд шивэх ажлыг хийж гүйцэтгэлээ. Хагас жилийн мал тооллогоор Хараа баг адуу-1024, үхэр-1414, хонь-6219, ямаа-4108 бүгд 12770 толгой мал, Баян баг адуу-733, үхэр-1687, хонь-7338, ямаа-2535, бүгд 12293, Гонир баг адуу-733, үхэр-1336, хонь-2541, ямаа-2503, бүгд 7113, нийт=32176 тоо толгой мал тоолуулсан байна.

Тариалангийн талбайд мал, тэжээвэр амьтан орж талбайг талхалж, ургац алдах, талбайд орсон малыг удаан хугацаагаар хаших зэргээс шалтгаалан малчин тариаланчдад хохирол учруулсан зөрчлүүд гарч байгаатай холбоотой малчин, тариаланч нартай гурвалсан гэрээ хийж ажиллах талаар ХХААГ-аас ирсэн бичгийн хүрээнд Сумын Засаг даргын 2023 оны А/123 тоот “Таримал ургамлыг мал, гэрийн тэжээвэр амьтдаас хамгаалах зарим арга хэмжээний тухай” захирамжийн дагуу гурвалсан гэрээг малчин, тариаланч, багийн Засаг дарга, 4 аж ахуй нэгж, 9 иргэнтэй гэрээ байгуулсан.

Газар тариалангийн хуулийн дагуу бүс нутагт нутагладаг малчдыг өвөлжөөнөөс нүүх мэдэгдлийг багийн Засаг дарга цагдаагийн хэсэгтэй хамтран хүргүүлж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Сумын хэмжээнд буудай 5674 га ногоон тэжээл 378 га, эрдэнэшиш 10,4 га, шар буурцаг 40 га, гурвалжин будаа 9 га, овьёос 156 га, арвай 15 га, төмс 94 га, бусад ногоо 69 га нийт тариалсан талбай 8254,4 га тариалалт 100 хувьтай дууссан байна.

Мал амьтны гоц халдварт БММӨ-нөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт эхэлсэн ба 96% буюу 108672 толгой мал хамруулаад байна.

Хоршоог хөгжүүлэх сангаас хүнсний ногоо тарих, хүлэмжийн аж ахуйн чиглэлээр 3,0-35,0 сая төгрөгий зээл олгохоор шийдвэрлэж төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөл 2023 оны 05 сарын 26-ны өдөр хуралдаж 4 иргэнд нийт 54,0 сая төгрөгийн зээл олгосон.

#### **Ерөө сум:**

Хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын өдрийн арга хэмжээг аймгийн хэмжээнд “Нэгдүгээрт хүүхэд”, “Найз байя” уриан дор тэмдэглэн өнгөрүүлэх тухай чиглэлийн дагуу сумын хэмжээнд 2023 оны 06 сарын 01-ний өдөр зохион байгуулан өргөн дэлгэр тэмдэглэн өнгөрүүллээ. Баярын өдөрт зориулан 10 төрлийн тэмцээн уралдаанд 613 хүүхдийг хамруулан 160 хүүхдийг байр эзлүүлэн шагнаж урамшууллаа.

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн арга хэмжээнд зориулан 43 нөхөрлөл, аж ахуйн нэгж, хүнсний дэлгүүр, мухлаг, 1 иргэн хандив өгч 385 бэлгийг Ерөө сумынхаа ирээдүй бяцхан үрүүдэд өгч баярлууллаа. Мөн энэ өдөр 14 ээж алдарт эхийн 2-р зэргийн одонгоор шагнагдлаа.

Сумын Засаг даргын захирамжаар гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр газар өмчлөхөөр хүсэлт гаргасан 14 иргэнд нийт 2.6 га газрыг нэг удаа өмчлүүлээд байна.

Сумын Засаг даргын А/178, А/186, А/177, А/180 дугаар захирамжаар худалдаа үйлчилгээ болон өвөлжөө, хаваржааны зориулалттай болон 4 нэгж талбарын 3399м<sup>2</sup> газрыг 4 иргэнд тус тус 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүллээ.

Аймгийн Засаг даргын 2023 оны А/282 дугаар “Ажлын хэсэг байгуулах тухай” захирамж болон аймгийн ГХБХБГазраас ирүүлсэн албан бичгийн хүрээнд тариалангийн газрын зөрчилтэй нэгж талбарын бүртгэл судалгаанд орсон 107 нэгж талбарын 91 нэгж талбарын гэрээг дүгнэн ажилласан.

Сумын Засаг даргын 2023 оны А/169 тоот захирамжийн дагуу 06 дугаар сарын 03-ны өдрөөс 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдөр хүртэлх хугацаанд статистикийн хэлтсээс ирүүлсэн 113 малчин, мал бүхий өрх, 1 аж ахуйн нэгжийн малын хагас жилийн түүвэр тооллого зохион байгуулсан.

Үүнд:

Адуу-1210

Үхэр-3236

Хонь-5111

Ямаа-5238 нийт 14795 толгой мал тоолуулж, 1077 толгой мал хорогдсон байна.

Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт эхэлж 68000 толгой богд дархлаажуулалт хийгдэж 80 хувийн гүйцэтгэлтэй байна. Гарал үүслийн гэрчилгээ 120 ширхэгийг олгосон байна.

Ерөө сумын Залуусын нэгдлээс санаачлан “Ерөө сумын малчин залуусын уулзалт-2023” арга хэмжээнд тус сумын 18-40 насны 50 залуу малчид оролцлоо. Арга хэмжээний хүрээнд Эртэч Монгол хөтөлбөрийн сургагч багш Б.Төмөр-Очир “Хувь хүний хөгжил” сэдвээр болон Ерөөгийн залуусын нэгдлээс “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого-д тусгагдсан холбогдох хөтөлбөр арга хэмжээний талаар мэдээллийг хүргэн 2 төрөлт тэмцээн зохион байгууллаа.

Ажил хайгч иргэний анкет болон “БТЕГ” ХХК-ний ажилд орохыг хүсэгчийн анкет бөглөсөн 4 иргэний анкетыг системд бүртгэж энэ сард 4 иргэнийг шинэ ажлын байранд зуучилж ажиллалаа.

“Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох хосолмол аргачлалаар” сумын хэмжээний 26 өрхөөс судалгааг авч РМТ программд шивж илгээлээ.

Хоршоо хөгжүүлэх сангийн орон тооны бус хяналтын зөвлөлийн гишүүнтэй хамтран чанаргүй зээлийн ангилалд орсон 11 иргэнд мэдэгдэх хуудас өгч хяналтын хуудас хөтлөн зээлээ бүрэн барагдуулах, шүүх байгууллагад шилжүүлж байгааг мэдэгдэж ажиллаа.

Амралт, аялал зугаалгын улирал эхэлсэнтэй холбогдуулан голын эрэг дагуу аялж, амарч буй иргэдэд хүүхдийг хараа хяналтгүйгээр гол мөрөн, нуур, цөөрмийн орчимд тоглуулахгүй, орхихгүй байх, архи согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гол руу ойртохгүй байх, бороотой, гол мөрний усны түвшин нэмэгдсэн үед баталгаатай гүүр, гарам гарцтай газраар автомашинтай зорчих талаар заавар зөвлөмж өгч “Усны ослоос урьдчилан сэргийлье” гарын авлага бэлтгэн голын эрэг дагуу амарч, зугаалж буй 80 гаруй иргэнд тараалаа.

### **Жавхлант сүм:**

Сумын Засаг дарга бөгөөд Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүн Ц.Дарханбаатар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөж байгаа сурагчдыг хүлээн авч уулзан, Улаанбаатар хотод их, дээд сургуулиудтай танилцуулах аяллыг зохион байгууллаа.

Дэлхийн Зөн Монгол олон улсын байгууллага Сэлэнгэ нутгийн хөтөлбөрийн Жавхлант сумыг хариуцсан мэргэжилтэн Б.Батжаргал нь сумын Иргэний нийгмийн /Ахмадын холбоо, Эмэгтэйчүүдийн холбоо, Залуучуудын холбоо/ байгууллагуудын төлөөлөлтэй уулзалт, хэлэлцүүлэг зохион байгууллаа. Тус уулзалтаар сумын Иргэний нийгмийн байгууллагуудын чадамжийн өөрийн үнэлгээг хийх заавар зөвлөмжийг өглөө. Үнэлгээнд тулгуурлан цаашид зохион байгуулах үйл ажиллагаагаа төлөвлөх юм.

Авлигатай тэмцэх газраас "Шүгэл үлээх ажиллагаа"-ны хүрээнд зохион байгуулж буй "Нэгдье", "Үгүй гэж хэлээд өөрчилье" авлигын эсрэг нөлөөллийн аян улс орон даяар эхэллээ. Тус нөлөөллийн аянд төр төсвийн байгууллагууд бүрэн нэгдлээ.

Стрийм төслийн санхүүжилтээр хийгдсэн мод үржүүлгийн талбайд Монгол сакура буюу бүйлсний яст үр 2 кг, шар хуайс 2 кг үрийг тус тус тарьж суулган, усалгаа арчилгааны ажил хийгдэж байна. Мөн 12 ш Монгол сакураны суулгацыг тарьж суулгасан. 2022 онд уг мод үржүүлгийн талбайд үрээр тарьсан агч, гүйлсний суулгац 80 хувийн ургалттай байна.

Дотуур байранд суралцагчийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах, эцэг эхийн хамтын ажиллагаа оролцоог нэмэгдүүлэх, хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор хүүхэд хөгжлийн танхимыг Дэлхийн Зөн олон улсын байгууллагын 8,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар тохижууллаа.

Жавхлант суманд "Соёлын сэргэлт-2023" аяныг дараах хөтөлбөрийн хүнээд зохион байгууллаа. Үүнд:

-Соён гэгээрүүлэх илтгэл, сургалтыг боловсролын ажилтан, сургагч багш Т.Мөнхтүвшин “Бүх нийтийн соёлын боловсрол” сэдвээр иргэдэд илтгэл тавилаа.

-Байгалийн түүхийн музейн захиргаа аж ахуйн хэлтсийн дарга Т.Дашбат, боловсрол, маркетингийн хэлтсийн дарга О.Соронзонболд нар сумын Соёлын төв болон музейн ажилтан албан хаагчидтай “Орон нутаг судлах танхимыг хөгжүүлэх боломж, хэрэгцээ шаардлага, гэрэл зураг ба баримтжуулалт”-ын чиглэлээр зөвлөгөө өгч, туршлага, санал солилцлоо.

-Байгалийн түүхийн музейн сан хөмрөгт хадгалагдаж буй зэрлэг амьтдын чихмэлээс бүрдсэн 30 гаруй үзмэртэй “Байгалийг ойроос” зэрлэг амьтдын нүүдлийн бэсрэг үзэсгэлэн, Монгол орны байгаль, ан амьтдын шилдэг гэрэл зурагчдын бүтээлийн “Танилцъя” үзэсгэлэн,

-Сэлэнгэ аймгийн хүүхэд багачуудын оролцсон “Байгаль бидний гэр” тэмцээний шилдэг 80 орчим гар зургийн үзэсгэлэн

-Урлагийн тоглолтыг үзүүллээ.

2023 оны 6 дугаар сарын 16-нд Сэлэнгэ аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбоо нь аймгийн 17 сум, 6 тосгоны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл оролцсон "Зүрхэндээ нартай хүмүүс" урлагийн тоглолтыг амжилттай зохион байгуулан үзэгч түмэндээ толилууллаа.

### **Зүүнбүрэн сум:**

Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарласантай холбогдуулан хууль бус үйлдэлтэй үл эвлэрэх, авлигыг үл тэвчих үзэл, хандлагыг төлөвшүүлэх, хүнд суртал, чирэгдлийг арилгах, төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдлыг хангах, авлигын эрсдэлийг бууруулах зорилгын хүрээнд “Авлигын эсрэг НЭГДЬЕ” үндэсний хэмжээний нөлөөллийн аянд сумын хэмжээнд нэгдэн төр, төсвийн байгууллагын цахим хуудсаар авлигын эсрэг шторк мэдээллийг иргэдэд хүргэн, сурталчлан ажиллаж байна.

2023 оны 06 дугаар сарын 14-ний өдөр “Гацуурт” ХХК тус сумын нутаг дэвсгэрээр дамжин Цагааннуур сумын нутаг руу оруулахаар олон тооны адуу тууварлан ирсэнтэй холбогдуулан 06 дугаар сарын 15-20-ны өдрүүдэд холбогдох арга хэмжээг авч сумын Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн “Тариалангийн бүс нутгаас малыг албадан гаргах тухай” А/109 дүгээр захирамжийг гарган хэрэгжилтийг ханган ажиллаж уг адууг сумын нутаг дэвсгэрээс гарган Хушаат сумын холбогдох албан хаагчдад хүлээлгэн өгч ажиллалаа.

Аймгийн Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, хошууч Г.Батсүхээр ахлуулсан ажлын хэсэг Зүүнбүрэн суманд ажиллаж,



болзошгүй гамшгийн аюул, хүн ам, хүрээлэн байгаа орчныг хамгаалах, урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулашгүй сэргээн босгох үйл ажиллагаанд аж ахуй нэгж, байгууллага, иргэдийг сургах, харилцан сайжруулах бэлэн байдлын үзлэг, хяналт шалгалт, гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийж, сургалт зохион байгууллаа.

Аймаг, сумын Засаг даргын 2023 оны А/293, А/93 дугаар захирамжийн дагуу 2023 оны малын хагас жилийн түүвэр судалгааны ажлыг 89 өрхийн **13684** мал буюу адуу 894, үхэр 2451, хонь 5324, ямаа 5015 хийж ажиллалаа.

Сумын Засаг даргын “Үржлийн малд үзлэг ангилалт хийх тухай” А/110 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган 15 өрхийн 4151 толгой бог малд үзлэг ангилал хийж ажиллалаа.

Сумын 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу цахим дуудлага худалдаа зохион байгуулж ялагчаар шалгарсан 1 аж ахуй нэгжтэй гэрээ байгуулж сумын Засаг даргын захирамжаар 0.22 м2 газрыг эзэмшүүлсэн.

Хоршоо хөгжүүлэх сангаас 2013 онд зээл аваад төлөөгүй 3 иргэнийг Шүүхийн эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд урьж эвлэрлийн гэрээ хийснээр 3,670,487 төгрөгийн зээлээс 999,333 төгрөгийн зээл төлөгдөж тус сард 1,725,000 төгрөгийн эргэн төлөлт хийгдлээ.

Дархан-Алтанбулагийн замаас Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн 120,85 км хатуу хучилттай автозамын ажил гүйцэтгэж буй “Монгол ЛЗ зам гүүр” ХХК-ийн туслан гүйцэтгэх “Тал нутгийн үзэмж” ХХК-ийн ажилчдын хоол хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдалд хяналт шалгалт хийхэд хүнсэнд хэрэглэгдэж буй мах нь гарал үүсэл тодорхойгүй, хоол үйлдвэрлэлд ажиллаж байгаа 2 тогооч эрүүл мэндийн шинжилгээ өгөөгүй, гал тогоонд хэрэглэгдэж байгаа савнууд нь зориулалтын бус, хоолны нэр төрөл, материал хэт хягаарлагдмал байгаа нь авах ёстой хоногийн илчлэгт нормд хүрэхгүй зэрэг зөрчил илэрсэн. Улсын байцаагчийн зүгээс хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллалаа.

Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөртэй холбогдуулан хүнсний дэлгүүрүүдэд хугацаа хэтэрсэн, хадгалалт, хамгаалалтын горим зөрчигдсөн, сургууль цэцэрлэгийн орчимд худалдан борлуулахыг хориглосон бүтээгдэхүүн худалдаалж байгаа талаар хяналт хийн илэрсэн зөрчлүүдийг газар дээр нь арилгууллаа.

Сумын хэмжээнд 2019 оноос хойш шинээр бий болсон 1 усалгаатай тариалан, 36 худаг уст цэгт тооллого хийн бүртгэлжүүлсэн.

Төвийн хөрөнгө оруулалтаар:

-“Төвийн худгийг камержуулах” ажлыг “Баяжих Ундарга” ХХК шалгарч 4,983,000 төгрөгөөр 100 хувийн гүйцэтгэлээр хүлээлгэн өгсөн.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар:

-“Төвийн худгийг Смарт картжуулах” ажилд “Баяжих Ундарга” ХХК шалгарч 19,965,000 төгрөгөөр 100 хувийн гүйцэтгэлээр хүлээлгэн өгсөн.

-Ерөнхий боловсролын сургуулийн “Дотуур байрны хатуу зөөлөн эдлэл нийлүүлэх” ажилд “БЗД” ХХК шалгарч 57,895,500 төгрөгөөр 100 хувийн гүйцэтгэлээр хүлээлгэн өгсөн.

Орон нутгийн хөгжлийн сангийн малын тоо толгой албан татварын хөрөнгө оруулалтаар:

-“Байгалийн гамшиг ослын үед авран хамгаалах, зам даваа засах, тусгай тоног төхөөрөмж” нийлүүлэх ажилд “Интерконсалтинг констракшн” ХХК шалгарт 94,500,000 төгрөгөөр 100 хувийн гүйцэтгэлээр хүлээлгэн өгсөн.

### **Мандал сум:**

Мэдээллийн ил тод байдлыг хангах, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх зорилгоор зохион байгуулагдаж байгаа ажил үйлчилгээ түүнтэй холбоотой мэдээлэл, цаг үеийн мэдээ, ИТХурлын мэдээлэл, Засаг даргын Тамгын газрын мэргэжилтнүүдийн мэдээлэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан ажлуудын явцын хэрэгжилт, цаг үеийн мэдээллийг фото, видео хэлбэрээр бэлтгэн ажиллалаа. Фото-60 , видео-11 хэлбэрээр сумын Засаг даргын Тамгын газрын албан ёсны цахим хуудсанд цаг үеийн мэдээ 16, үйл явдлын мэдээ 42, зарын агуулга бүхий 13 нийт мэдээ, мэдээллийг бэлтгэн байршууллаа.

Монгол Улсын их хурлын гишүүн Д.Өнөрболор“Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн хэлэлцүүлэг” , “Сэтгэл зүйн сургалт” зохион байгуулагдаж 250 гаруй төрийн албан хаагч, иргэд хамрагдлаа. УИХ-ын гишүүдийн тоог 152 болгоход санал 100 хувь санал нэгдээгүй тодорхой хэмжээгээр нэмсэн нь зүйтэй гэдэг саналыг иргэд дэвшүүлээ.

Монгол Улсын Засгийн газрын 339, 340 дүгээр тогтоолын дагуу Стратегийн команд штабын сургуулийн үед дадлага сургуулийг зохион байгуулж иргэдийг нүүлгэн шилжүүлэн 1,6-р, 2.9-р баг, 3.7-р баг, Хэрх, Түнхэл, Тарни баг нийт 6 цугларах талбайд 334 машин нийт 1930 иргэд цуглуулсан.

“Тогтвортой Амжиргаа-3” төслийн сургалт зохион байгуулж, “Малын тоо толгойн албан татварын тухай” хууль батлагдан хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Татварын орлогоОНХС-д хэрхэн төвлөрүүлэх, зарцуулах, тайлагнах чиглэлээр Орон нутгийн төслийн ажилтан, сумын татварын байцаагчидтай хамтран төслийн сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтад иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, хурлын төлөөлөгчид, багийн засаг дарга нар 30 төрийн албан хаагчид хамрагдлаа.

Хүний эрхийн Үндэсний комиссоос Мандал сумын төрийн албан хаагч, иргэдэд чиглэсэн Хүний эрхийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, эрхээ хамгаалах, зөрчигдсэн эрхээ сэргээх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа хүний эрхэд суурилсан, хандлага арга зүйгээр явуулах арга барилд суралцах зорилгын хүрээнд зохион байгууллаа. Сургалтад 10 байгууллагын 65 гаруй албан хаагчид хамрагдлаа.

“Бороо Гоулд” ХХК-ний Нээлттэй хаалганы өдөрлөг 2023.05 дугаар сарын 31-ний өдөр Мандал сумын Засаг дарга Тамгын газартай хамтран ажлын байрны мэдээлэл өгч, ярилцлага хийж ажилтан сонгон шалгаруулж авах зэрэг үйл ажиллагаа зохион байгууллаа.

Сэлэнгэ аймгийн Мандал сум нь Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг “НЭГДҮГЭЭРТ ХҮҮХЭД” уриан доор, хүүхдийн эрхийг хангах чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, тэдний авьяас чадварыг дэмжих санал, санаачлагыг өрнүүлэх, оролцоог ханган зохион байгуулах ажлын хэсгийг сумын Засаг даргын 2023 оны А/161 тоот захирамжаар байгуулан, хөтөлбөр удирдамжийн дагуу хүүхэд, залуус урлаг уран сайхны үзүүлбэр үзүүлж ажиллалаа.

Мөн хүүхдүүдэд мэдээлэл олгох, албан байгууллагын үйл ажиллагааг танилцуулах Хотхоныг байгуулан хүүхдүүдийн дунд уран зургын уралдаан, дугуйн уралдаан болон спортын тэмцээнүүдийг зохион байгуулан, гарын бэлэг гардууллаа.Сумын ерөнхий боловсролын сургуулиуд “Найз байя” аяны хүрээнд

хүүхдийг үе тэнгийн дарамт дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх аяны хүрээнд сургуулийн хүүхэд хамгааллын багаас дунд ангийн сурагчдын дунд "ҮЕ ТЭНГИЙН ДЭЭРЭЛХЭЛТИЙГ ЗОГСООЁ" "НАЙЗ БАЙЯ" сэдвийн хүрээнд сургалт зохион байгууллаа.

Зүүнхараа дахь Монголын Оюун Ухааны академийн үйл ажиллагааг сурталчилан таниулах хотхон байгуулж, олон улсын тэмцээний аварга сурагчид болох Б.Итгэлмаа, Б.Нандин, Б.Сумьяажав, Н.Балжинням мөн Төвийн болон Хараа бүсийн аварга шалгаруулах тэмцээний алт, мөнгө, хүрэл медальт тамирчдын амжилт бүтээлийг сурталчлан, гарын бэлэг гардуулан шагнаж урамшууллаа.

Тус үйл ажиллагааны үеэр Мандал сум дахь сум дундын цагдаагийн хэлтэсийн хүүхдийн байцаагч, Нэгдсэн эмнэлэгийн түргэн тусламжийн эмч, Хүнс жижиг дунд үйлдвэрлэл хоршоо хариуцсан мэргэжилтэн нар хамтран ажиллаж хүүхдийг аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх тал дээр хяналт тавьж ажиллалаа.

Мөн Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2023 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 53 дугаар зарлигаар Мандал сумын хэмжээнд Алдарт эхийн одон авч буй 61 эхээс 48 эхэд одонг гардуулах ёслолын үйл ажиллагааг зохион байгууллаа. Үйл ажиллагааны үеэр Мандал сумын эмэгтэйчүүдийн холбоотой хамтран 9 өргөмжлөлт ээжийг шалгаруулж өргөмжлөл, тэмдэг, дурсгалын зүйл гардууллаа. "Мөнгөн хараа" дуу бүжгийн чуулгын уран бүтээлчид болон "Зүүнхараа Хүүхдийн ордон"-ий авьяаслаг багачууд урлагын үзүүлбэрээр ээжүүддээ мэндчилгээ дэвшүүллээ.

2023 оны Паравoleyболын Улсын аварга шалгаруулах тэмцээн Сэлэнгэ аймгийн Мандал суманд 06 дугаар сарын 3, 4-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулагдан өндөрлөлөө. Тэмцээнд нийт эмэгтэй 8, эрэгтэй 8 багийн 100 гаруй тамирчид хурд хүчээ сорин өрсөлдсөнөөс эрэгтэй төрөлд Сэлэнгэ аймгийн Мөнхбат ахлагчтай баг тамирчид алтан медаль, аваргын цом, эмэгтэй төрөлд Сэлэнгэ аймгийн Нямбаяр ахлагчтай баг тамирчид алтан медаль аваргын цомыг хүртсэн амжилтыг үзүүллээ. Харин тэмцээний 2 дугаар байрыг эрэгтэй төрөлд Хөвсгөл аймгийн Тэрбиш ахлагчтай баг тамирчид , 3 дугаар байрыг Ганзориг ахлагчтай Сонгинохайрхан дүүргийн баг тамирчид, Эмэгтэй төрөлд 2 дугаар байрыг Соёлсайхан ахлагчтай Хан-Уул дүүргийн баг тамирчид, 3 дугаар байрыг Төмөрсүх ахлагчтай Хөвсгөл аймгийн баг тамирчид тус тус эзэллээ.

Мөн тэмцээний шилдэг тамирчны шагналыг эрэгтэй төрөлд Сэлэнгэ аймгийн н.Баярхүү , эмэгтэй төрөлд Сэлэнгэ аймгийн Оюунжаргал нар тус тус хүртлээ. Тэмцээний хамтран зохион байгуулагчаар Мандал сумын Засаг дарга А.Дашзэвэг, Мандал сумын ЗДТГ, Монголын суугаа волейболын холбоо, Мандал сумын Спорт сургалтын цогцолбор, Мандал сумын Ардчилсан нам, Мандал сумын Социал - Демократ Монголын Залуучуудын холбоо нар ажиллалаа.

2023 элсэлтийн ерөнхий шалгалтын 10 хичээлд 1038 шалгуулагч бүртгүүлж, 2023.06.15-18-ны өдрүүдэд 92,26 хувийн ирцтэйгээр амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Аймгийн хэмжээнд 10 хичээлийн шалгалтын 6 хичээлд нь Мандал сумын ерөнхий боловсролын сургуулийн сурагчид хамгийн өндөр оноо авсан байна. Үүнд Мандал 1 дүгээр сургуулийн сурагч Э.Отгон-эрдэнэ биологийн хичээлээр 655 оноо, 3 дугаар сургуулийн Б.Энхжин химийн хичээлээр 685, 5 дугаар сургуулийн сурагч О.Санчир математик 773, физик 695, Хэрх сургуулийн сурагч А.Буянтөгөлдөр газарзүйн хичээлээр 675 оноо тус тус авч өндөр амжилт үзүүллээ.

“Эрүүл иргэн-2024 амны хөндийг эрүүлжүүлэх” сумын хөтөлбөрийн хүрээнд Мандал сумын нэгдсэн эмнэлэгийн шүдний кабинетэд 20 сая төгрөгийн үнэ бүхий 38 нэр төрлийн 196 ширхэг багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг 6 сарын 21-ний өдөр хүлээлгэн өглөө.

Байгаль орчны чиглэлээр дараах ажлууд хийгдэж байна. Үүнд:

-Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд харъяалалын дагуу шилжиж ирсэн 3 зөрчилд шалган шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна.

-Худалдааны гудамжинд үйл ажиллагаа явуулдаг төвийн дулаан, бохирт холбогдоогүй, нийтийн эдэлбэр газрыг зохих зөвшөөрөлгүй ашигласан 3 аж ахуй нэгж байгууллагад хугацаатай улсын ахлах байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн.

-Засаг даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлд улсын орлого болгож буй эд зүйлсийн талаарх улсын ахлах байцаагчийн акт гаргуулсан.

-Багийн Засаг дарга нарт багийн нутаг дэвсгэр дээр хог цэвэрлэгээг зохион байгуулах улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн.

-Сумын Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 19-ны А/216 дугаар “Ойд явуулах үйл ажиллагааг эхлүүлэх тухай” захирамж гарсан холбоотойгоор ойн мэргэжлийн байгууллагуудын доод агуулахад тооллого хийсэн.

-Хараа-Ерөө голын сав газрын захиргаатай хамтран 06 дугаар сарын 22-ноос усны тооллогын ажил хийгдэж байна.

-Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 02 албан даалгаварын хүрээнд сумын Засаг даргын 2023 оны А/204 тоот захирамжийн дагуу 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдөр сумын төвийн 3 байршилд бүх нийтийн хог цэвэрлэгээг зохион байгууллаа. Нийт 66 аж ахуй нэгж байгууллагын 1033 албан хаагч, 21 тээврийн хэрэгсэлтэй оролцож 1720тн хогийг хогийн цэгт төвлөрүүлэн, булшилсан.

-Аймаг зохион байгуулагдсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийн явц, үр дүн сэдэвт зөвлөгөөнд тус сумаас мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 8 иргэн, 6 нөхөрлөл, 2 хоршоо, 21 аж ахуй нэгж байгууллага ойн ангийн нийт 55 иргэн 19 нэр төрлийн 6321 ширхэг мод, бут, сөөгний тарьц суулгацааридэвхтэй оролцлоо.

-“Моносхон” цэцэрлэгийн ахлах бүлгийн 80 хүүхдүүд тэрбум мод аянд нэгдэж 200 ширхэг хайлаасны суулгац, 2 ширхэг бортоготой гацуур, 2 ширхэг бортоготой шинэс хүлээн авлаа. Өнгөрсөн амралтын өдрүүдэд хаврын мод тарилтын Үндэсний өдрийг тохиолдуулан сумын Засаг даргын Тамгын газрын 54 албан хаагчид Хараа голын гүүрнээс урагш 350м-н зайд 100ш мод тарин услаж, хашаажуулан ажиллалаа.

Хөдөө аж ахуйн чиглэлээр: НҮБ-н Хүнс Хөдөө аж ахуйн байгууллагийн stream төслийн санхүүжилтээр Япон улсаас 4 багш хүрэлцэн ирж 15 хүнд 3 хоногийн дрон ажиллуулах сургалт орж, Монгол улс дахь Япон улсын элчин сайдын яам, Жаяка Японы олон улсын байгууллага өвсний үндэс төслийн санхүүжилтээр Япон улсаас хөрс, хамгаалах бодис цацах, талбайн үнэлгээ дүгнэлт нарийвчилсан зураглал гаргах чадвартай 2 төрлийн дроныг Монголын хөдөөг шинэчлэхийн төлөө фермерүүдийн холбооны Мандал суман дахь салбарт хүлээлгэн өгч ажиллаа.

Дэд бүтэцийн чиглэлээр: Мандал сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан бохирын шугам хоолой суурилуулах ажил ажилттай зохион байгуулагдлаа.

Инженерийн шугам хоолой суурилуулах эрх бүхий" Цагаан Зуун"ХХК Мандал суманд Улсын төсвийн 3,9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар бохир ус татан зайлуулах 7км -н шугам хоолой суурилуулах ажлыг зураг төсвийн дагуу 2022 оны 08 дугаар сараас хийж гүйцэтгэн 2023 оны 06 сарын 24-ний өдөр Улсын комиссд хүлээлгэн өглөө.

Айл өрх аж ахуй нэгжийг дэд бүтцийн хувьд бохирын шугамд холбох зорилго бүхий шугам суурилуулах ажлын дүнд одоогоор шугам холбогдсон хэсэгт 35 аж ахуй нэгж 11 айл өрх бохирын төвлөрсөн шугамд холбогдоод байна. Цаашид Тус бохирын шугам хоолойн ашиглагчаар "Цант Орхон" ОНӨААТҮГазар хариуцан ажиллах бөгөөд гүйцэтгэгч компаний ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажиллаа.

2023 онд сумын төсвийн хөрөнгө оруулалтаар Түнхэл тосгон, Ажнайн давааны хэсэгт хийгдэх 9.3 км зам засварын ажлын явц 60 хувьтай явагдаж байна. Ажилын зураг төсвийн дагуу хусах, тэгшлэх, дунджаар 20см-ийн зузаантай хайргаар хучих ажлууд Ажлын хэсгийн зүгээс хяналт тавин ажиллаж байна. "Ноблероуд ХХК"-тай хийсэн зам засварын ажил гэрээний дагуу 7 дугаар сарын 15 гэхэд дуусах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Мандал сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд "Амны хөндийн эрүүл ахуй" дэд хөтөлбөр хэрэгжиж ажиллаа. Энэ ажлын хүрээнд өнөөдөр Мандал сумын Нэгдсэн эмнэлэгт 20 сая төгрөгийн өртөг бүхий 38 төрлийн 196 ширхэг багаж тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэн орчин үеийн багаж тоног төхөөрөмжийг хүлээлгэн өглөө.

Мөн сумын ИТХурлаар батлагдсан тус хөтөлбөрийн хүрээнд Мандал сумын Түнхэл 5дугаар баг, Хэрх 4дүгээр багт тус тус хөрөнгө оруулалтыг сумын удирдлагын зүгээс шийдвэрлэн шүдний кабинетыг нээн ажилуулж Эрүүл иргэн хөтөлбөрийн хүрээнд амны хөндийн эрүүл ахуйд чиглэсэн үзлэг эмчилгээг цаг алдалгүй хийн ажиллаж байна. Мандал сумын Нэгдсэн эмнэлгийн зүгээс хөтөлбөрийн хүрээнд уртасгасан цагаар шат дараалсан амны хөндийн үзлэг оношилгоог цэцэрлэг, сургууль байгууллагууд гэсэн хуваарьтайгаар ажиллаж байна.

Мөн Монгол улс дахь Япон улсын элчин сайдын яам, Японы Жаяка Олон Улсын байгууллага, "Өвсний үндэс төсөл"ийн санхүүжилтээр Япон улсаас хөрс хамгаалах бодис цацах, талбайн үнэлгээ дүгнэлт нарийвчилсан зураглал гаргах чадвартай 2 төрлийн дроныг "Монголын хөдөөг шинэчлэхийн төлөө фермерүүдийн холбоо"ны Мандал сум дахь салбарт хүлээлгэн өглөө. Энэхүү ажлын хүрээнд НҮБ-н Хүнс Хөдөө аж ахуйн байгууллагын Stream төслийн санжүүжилтээр Япон улсаас 4 сургагч багшийг урин 15 хүнд 6 дугаар сарын 15-18-ны өдрүүдэд дрон ажиллуулах сургалтыг амжилттай зохион байгуулагдлаа.

### **Орхон сүм:**

"Нэгдүгээрт хүүхэд" уриан дор олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүллээ. Энэхүү арга хэмжээний үеэр Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2023 оны 53 дугаар зарлигаар алдарт эхийн 2-р зэргийн одонгоор 9 иргэн шагнагдлаа. Мөн "Уран бэр" тэмдгээр 3 иргэн шагнагдсан байна.

Мөн хүүхэд багачуудад зориулан олон төрөлт тэмцээнийг төр, төсвийн 4 байгууллагаас тус бүр хариуцан зохион байгуулж ажиллалаа. Үүнд талбайн гар зургийн уралдаан, унадаг дугуй, дүрс өнгөөр ялгах зэрэг уралдаант тэмцээнүүд болж өндөрлөлөө.

Монгол Улсын хэмжээнд Гамшгаас хамгаалах Команд штабын сургуулийг 2023 оны 06 дугаар сарын 07-09-ний өдрүүдэд зохион байгууллаа. Гамшгийн

үеийн дуут дохиог 2023 оны 06-р сарын 08-ны өдрийн 16:00 цагт дуугарган, нүүлгэн шилжүүлэлтийн түр цугларах талбайд суурин хүн амыг цуглуулах дадлага сургуулийг зохион байгууллаа. Тус ажиллагааны хүрээнд сумын төвийн 84 иргэнийг нүүлгэн шилжүүлж аюулгүйн цэгт цуглууллаа.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийг мэдээ мэдээллээр хангах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлын хүрээнд тус сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Сайхан сум дахь сум дундын Шүүх, Прокурорын газар, сум дундын Цагдаагийн хэлтэстэй хамтран “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг 2023 оны 06 дугаар сарын 21-ны өдөр зохион

Байгаль орчны чиглэлээр: Сумын Засаг даргын 2023 оны “Тариалангийн талбай, өвөлжөөний газрыг малын хөлөөс чөлөөлөх тухай” А/51 тоот захирамжийг зөрчсөн Орхон сумын харьяат 2 малчинд тус бүр 50.000 төгрөгийн, зөвшөөрөлгүй газарт ил задгай хог хаягдал хаясан 1 иргэнд 30.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээг Зөрчлийн хуулийн дагуу тооцож ажиллалаа.

Бэлэндалай 2-р багийн нутагт байрлах 42-р зөрлөгийн төвлөрсөн хогийн цэгийн хог хаягдлыг дарж булах, талбайн хэмжээг багасгах ажлуудыг зохион байгууллаа.

Түгээмэл тархацтай ашигт малтмал элс, хайрга ашиглах гэрээг 8 иргэнтэй байгуулан нөөц ашигласны төлбөрт орон нутгийн төрийн сангийн дансанд 483.000 төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хөдөө аж ахуйн чиглэлээр: Сумын хэмжээнд газар тариалангийн чиглэлээр нийт 12698га талбайд тариалалт хийсэн.

Сэлэнгэ аймаг, Япон улсын Шизуко муж хоорондын хамтын ажиллагааны хүрээнд төмс, хүнсний ногооны эрхлэгчдэд зориулсан танхимын болон талбайн сургалтыг зохион байгууллаа. Талбайн сургалтыг “Орхон түшиг ургац” ХХК-ний тариалангийн талбайд практик сургалтыг зохион байгуулж, туршлага судаллаа. Сургалтад нийт 23 ногоочдыг хамрууллаа.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны А/278 тоот захирамж, сумын Засаг даргын 2023 оны “Бог малын үзлэг ангилалтыг зохион байгуулах тухай” А/61 тоот захирамжийн дагуу Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг бог малын үзлэг ангилалтын ажлыг 2023 оны 05 дугаар сарын 22-27-ны өдрийн хооронд “Мал ангилалтын заавар”-ын дагуу зохион байгуулж, Орхон үүлдрийн хонь маллагч 3 аж ахуйн нэгж, 10 малчин өрхийн 2467 толгой “Орхон” үүлдрийн хонийг хамрууллаа.

Нийт үзлэг ангилалтад хамрагдсан “Орхон” үүлдрийн хониноос 2392 толгой хээлтэгч, 75 толгой хээлтүүлэгчийг үзлэг ангилалтад оруулж, анги чанарыг тогтоолоо. Ангилалтад хамрагдсан хээлтэгчийн 2.4 хувь шилмэл, 9.6 хувь 1-р анги, 9.4 хувь 2-р анги, 78.5 хувь 3 ба түүнээс дээш ангид хамрагдсан байна. Нийт хээлтэгчийн 22.6 хувь шилмэл, 41.3 хувь 1-р ангид, 36 хувь бусад ангид ангилагдсан байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны “Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг зохион байгуулах тухай” А/303 тоот, сумын Засаг даргын 2023 оны “Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг зохион байгуулах тухай” А/69 тоот захирамжийн дагуу дархлаажуулалтын ажлыг технологит хугацаанд зохион байгууллаа. Дархлаажуулалтын ажлыг “Эгдэм” БГБХН, “Бүрэн-Орхон” ХХК МЭҮНэгжүүд болон мал эмнэлгийн тасгууд хамтран зохион байгуулж нийт 171 өрхийн 77800 ямааг хамрууллаа.

Дархлаажуулалтын шатахуун болон бусад санхүүжилтийг сумын Орон нутгийн хөгжлийн сангийн “Малын тоо толгойн албан татвар”-аас “Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээ авах ажлын хүрээнд “Бүрэн-Орхон” ХХК-тай 3.783.401 төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллалаа.

### **Орхонтуул сум:**

Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургууль 2023 оны 6 дугаар сарын 08-ний өдрийн 16:00 цагт Орхонтуул сумын хэмжээнд 1 минутын зайтай 3 удаа дохио дуугарган зохион байгууллаа. Дуут дохиогоор Түр цугларах талбайд Сумын хэмжээнд ЗДТГазар, ЕБС, 1-р цэцэрлэг, ЭМТөв, Соёлын төв, Хаан банк, Төрийн банк, Ник ШТС, худалдаа үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, газар тариалан чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч ААН, иргэд, хүүхдүүд томилогдсон бүртгэлийн ажилтнуудад бүртгүүлээ. Түр талбайд ирсэн иргэдийг авч үзвэл 25 техник хэрэгсэл, хүүхэд-107, том хүн-305 нийт 412 иргэд оролцлоо.

### **Улсын бүртгэлийн ажил үйлчилгээний хүрээнд:**

-Шинэ төрсөн хүүхдийн бүртгэл –5, Гэрлэлтийн бүртгэл –1, Нас барсны – 2, Төрсний дахин гэрчилгээ – 0нийт 8 бүртгэлийн нотлох баримтыг хүлээн авч бүртгэн гэрчилгээ олгосон.

-Шилжин ирсэн 5 иргэн 2 хүүхдийг иргэний бүртгэлийн цахим санд бүртгэн баталгаажуулалтыг хийж ажиллалаа

-Иргэний үнэмлэх: Шинээр-4, сунгалт- бхэвлэгдэн гарсан нийт 10 иргэний үнэмлэх зохих эздэд нь хүргэсэн

-Лавлагаа – 27, иргэнд – 22, албан хэрэгцээнд -5

-6 дугаар сард 34 иргэнд тоон гарын үсэг олгосон байна.

### **Нийгмийн даатгал:**

-Нийгмийн даатгалын төвлөрсөн санд ажил олгогч болон сайн дурын даатгуулагчдаас – 45,863.5 мян төгрөгийн шимтгэлийн орлого,

-ЭМД-ын санд 11 иргэн – 723.0 мян төгрөгийн эрүүл мэндийн орлого оруулж төлөвлөгөөний биелэлт -100%.

-Сайн дурын даатгалд малчин-1 ажилгүй-1 иргэн хамруулсан.

Дараах тэтгэвэр тэтгэмжүүдийг 6-р сард харилцагч банкуудаар дамжуулан олголоо.

-Өндөр насны тэтгэвэр - 467 иргэнд- 247,020.4 мян төгрөг

-Цэргийн өндөр насны тэтгэвэр – 3 иргэнд – 2,632.8

-Тахир дутуугийн тэтгэвэр – 124 иргэнд -56,883.8 мян төгрөг

-Тэжээгчээ алдсаны тэтгэвэрт- 22 иргэнд – 9,613.2 мян төгрөг нийт 316,150.20 төгрөгийг тэтгэврийн даатгалын сангаас олгосон байна.

-Оршуулгын тэтгэмж – 2 иргэнд -4000.0 мян төгрөг

-ХЧТА тэтгэмж – 2 иргэнд – 118.9 мян төг

-Жирэмсэн амаржсаны тэтгэмж – 3 иргэнд 3,849.6 мян төгрөг тус тус олгосон байна.

**Татварын чиглэлээр:** Улс, аймаг, сумын орлогын төлөвлөгөөний хуваарийн дагуу Улсын төсөвт 49472,50 , Аймгийн төсөвт 23787,80 Сумын төсөвт 271865,6 нийт 345125.9 мян/төг бүрдүүлэхээс Улсын төсөвт 121763.2 246,1%, Аймгийн төсөвт 27916,1 117,3%, Сумын төсөвт 297311,2%, 109.3%, Нийт 394268,9 мян/төг төсөвт төвлөрүүлэн 129,5% биелэсэн.

### **Хөдөө аж ахуйн чиглэлээр:**

Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зарласан Баянцогт 2-р багийн 1 орцтой орон сууцны барилгын дээвэр засвар, орцны хаалга шинээр солих

ажлын гүйцэтгэгчээр шалгарсан Гонирын зам ХХК-тай гэрээ байгуулан ажил эхлүүлэх зөвшөөрөл авах шатанд явагдаж байна. Мөн Баянцогт 2-р багт Хүнсний ногооны зоорь барих ажлын гүйцэтгэгч Кенорда ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна.

Баянцогт 2-р багийн 1 орцтой орон сууцны барилгын дээвэр засвар, орцны хаалга шинээр солих, Баянцогтын 2-р багт Бэлчээрийн худаг гаргах, Орхонтуул сумын Зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, замын гэрэлтүүлэг, Ариутгалын багаж хэрэгсэл худалдан авах ажлуудын нээлт хийгдээд байна.

05-р сарын 31-ний өдрөөс 06-р сарын 07-ны өдрүүдэд хагас жилийн малын түүвэр судалгааны ажил зохион байгуулагдаж, тус сумаас түүвэр аргаар сонгогдсон Шар-Усны 1-р баг 67, Баянцогт 2-р баг 47, Хонгор-Овоо 3-р баг 31 нийт 145 малчин, мал бүхий өрх, аж ахуйн нэгжийн малд тооллого явуулж, программд шивж ажилласан.

Хүнсэнд амьдаар Адуу-74, үхэр-67, хонь-2505, ямаа-622 бүтээгдэхүүнээр адууны мах-1020кг, үхрийн мах-4620кг, хонины мах-2750кг, ямааны мах-1230кг тус тус мал эмнэлгийн гарал үүслийн гэрчилгээ авч зах зээлд нийлүүлсэн байна. Мөн бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд 166200 толгой малыг хамруулан ажилласан.

### **Сант сүм:**

Сумын хэмжээнд 2519 га талбайд улаан буудай, 140 га талбайд овьёос, 490 га талбайд тосны ургамал, 140 га талбайд төмс, 176.7 га талбайд хүнсний ногооны тариалалт тус тус хийгдсэн. Үр тариа, төмсний тариалалт 100 хувь дуусаж, тосны ургамал, хүнсний ногооны тариалалт явагдаж байна.

Сумын хэмжээнд 124 өрхийн адуу 57, үхэр 557, хонь 474, ямаа 256 нийт 1344 том мал, 96 өрхийн унага 25, тугал 120, хурга 868, ишиг 829 нийт 1842 төл мал хорогдсон дүнтэй байна.

Сумын Засаг даргын “Малын хагас жилийн туувэр судалгаа зохион байгуулах тухай” 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/83 дугаар захирамжаар ажлын хэсэг томилогдон 05 дугаар сарын 30-наас 06 дугаар сарын 06-ны хооронд хагас жилийн мал тооллогын ажлыг зохион байгууллаа. Сумын хэмжээнд түүвэр судалгаанд 75 өрхийн 20768 мал хамрагдсанаас адуу 1080, үхэр 2707, хонь 10266, ямаа 6715 тоологдлоо.

БНСУ-ын хөдөөгийн хөгжлийн газрын харьяа “Монгол Копиа” төвийн санхүүжилтээр ХААИС-ийн мал аж ахуй биотехнологийн сургуулийн багш Ж.Шинэхүүгийн удирдан хэрэгжүүлж буй “Монгол улсад ферментжүүлсэн багсармал тэжээл үйлдвэрлэлийн технолгийг нутагшуулах” төслийн баг суманд 1 өдөр ажиллан төсөлд хамрагдсан 20 өрхөд ногоон тэжээл тариалах сургалт явууллаа. Төслийн зүгээс тариалалт хийхэд зориулан нэг өрхөд 5 шуудай арвай, 13 шуудай овьёосны үр, сумын хэмжээнд 14,4 тн ногоон тэжээлийн үрийг гардуулан өглөө. Тэжээл тариалах талбай болон хашаажуулах ажлыг сумын Засаг дарга шийдвэрлэн дэмжлэг үзүүлсэн.

Сумын нутаг дэвсгэрт бэлчээрийг ашиглаж буй мал бүхий иргэн, малчид, малчдын бүлэг, аж ахуйн нэгж байгууллагад бэлчээр ашиглуулах үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах, бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, сэлгэх, малын хөлөөс түр чөлөөлөх, нөхөн сэргээх, сайжруулах, бэлчээр шинээр эзэмшихтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор “Бэлчээр, хадлангийн талбай ашиглалтыг зохицуулах журам”-ыг боловсруулж сумын ИТХ-ын 2023 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 75 дугаар тогтоолоор батлууллаа. Бэлчээр ашиглах



журмыг хэрэгжүүлэх явцад төрийн албан тушаалтны хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй 2 иргэнд хариуцлага тооцож 100.000 төгрөгийн торгох шийтгэл оногдуулсан.

БОАЖЯ Орхон - Чулуут голын сав газрын захиргааны “Хамтран ажиллах тухай” 61 дүгээр албан тоотын дагуу усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалт, усны эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс тогтоох, усны тоо бүртгэлийн ажил зохион байгуулагдаж сумын нутагт дэвсгэрт орших гол 10, булаг 22, худаг 59, усан сан 1, нийт 92 уст цэгийг тооллогод хамрууллаа.

Амьтны хуулиар агнах, барихыг хориглосон цаг хугацаанд 15 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулж 2 зөрчлийг илрүүлж 2 иргэнд 600.000 төгрөгийн торгох шийтгэл, 76.000 төгрөгийн нөхөн төлбөр оногдууллаа.

Хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын өдрийн арга хэмжээг сумын хэмжээнд “Нэгдүгээрт хүүхэд” уриан дор тэмдэглэн өнгөрүүллээ. “Дэлхийн Зөн” Монгол ОУБ-тай хамтран хүүхдүүдийн дунд 11 төрлийн тэмцээн, уралдаан зохион байгуулж нийт 753000 төгрөгийн санхүүжилт зарцуулж давхардсан тоогоор баярын арга хэмжээнд 600 гаруй хүн хамрагдсан байна. Сурлага, урлаг, спортоороо бусдыгаа хошуучлан тэргүүлсэн сурагчдыг сумын Засаг дарга шагнаж урамшууллаа. Энэхүү арга хэмжээнд 500.0 төгрөгийг зарцуулсан байна.

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Алдарт эхийн нэгдүгээр одонгоор 1, хоёрдугаар одонгоор 4 эх шагнагдаж одонтой ээжүүдийн тоог нэмлээ.

Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн, “Алсын хараа-2050”, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдаж буй “Эерэг хандлага -Эрүүл нийгэм -Цаг гаргая” аяныг сумын Соёлын төвөөс сурталчлан 5 дугаар сарын 01-ний өдрөөс 7 сарын 01-ний өдрийг хүртэл өглөөний 06.30-08.00 цагийн хооронд эрүүл мэндийн дасгал хөдөлгөөн, шугаман бүжиг заах үйл ажиллагааг тогтмол зохион байгуулан төрийн албан хаагч, иргэдийг хамруулан ажиллаж байна.

“Соёлын өв” улсын эчнээ олимпиадын хүрээнд Соёлын төв, ЕБС-тай хамтран “Соёлын өв бидний амьдралд” эссэ бичлэгийн уралдааныг 9-12-р ангийн сурагчдын дунд зохион байгуулж 12 сурагч оролцлоо.

ЕБС-ийн аварга шалгаруулах гар бөмбөг, сагсан бөмбөгийн тэмцээнийг “Үе тэнгийн дээрэлхэлтийн эсрэг” уриан дор зохион байгуулж нийт 168 суралцагч оролцлоо.

СӨБ-ын байгууллагаас 6 дугаар сарын 06-наас эхлэн сарын хугацаатай зуны гэр цэцэрлэгийг хөдөө зусланд /Ивэн баг Тэлдийн чиглэлд/ ажиллуулж малчдын 15 хүүхэд хамрагдаж байна.

### **Сайхан сүм:**

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, Хүнсний тухай хууль, Зөрчлийн тухай хуулиудын хэрэгжилтийг хангуулах зорилгоор 06 дугаар сарын 21-ний өдөр Номгон 3-р баг Ширээ нурууны нутаг дэвсгэрийн 11 цэгт эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хориглосон газар үйлдвэрлэл үйлчилгээ явуулж байсан газруудад хяналт шалгалтын ажиллагаа явууллаа. Хүнсний аюулгүй байдал, стандарт чанарын шаардлага хангаж ажиллах биелэлтийн хугацаа хүртэл үйл ажиллагааг түр зогсоох тухай мэдэгдэл өгч зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажиллалаа.

Авлигатай тэмцэх газраас “Шүгэл үлээх ажиллагаа”-ны хүрээнд зохион байгуулж буй “Нэгдье”, “Үгүй гэж хэлээд өөрчилье” авлигын эсрэг нөлөөллийн аянд

нэгдэн аяны хүрээнд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Мал аж ахуйн чиглэлээр: Сумын Номгон 3-р багийн нутаг Ухаа хошуу гэх газарт 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 16 цагт мал амьтны гоц халдварт бог малын мялзан өвчний шинж тэмдэг бүртгэгдэж, 05 дугаар сарын 23-ны өдөр сумын Онцгой Комисс хуралдаж, Хорио цээрийн хэсэгчилсэн дэглэм 21 хоногийн хугацаатай тогтоох, байнгын пост болон хөдөлгөөнт эргүүл гаргах, Мялзан өвчний шинж тэмдэг илэрсэн малыг устгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар шийдвэр гарган ажилласан. 05 дугаар сарын 22-ноос 26-ыг хүртэл нийт устгасан бог малын тоо хоёр өрхийн 180 мал, устгалын ажлын хэсэгт нийт цаг үеийн нөхцөл, ажлын ачааллаас шалтгаалан 7-10 хүн, голомтын бүсэд байнгын хоёр пост 4 алба хаагч, хөдөлгөөнт эргүүлд 2 алба хаагч нийт сумын хэмжээнд 16 алба хаагч томилогдон ажилласан. Ариутгал хийсэн талбай 4442м<sup>2</sup> /хашаа, хороо, машин техник, багаж хэрэгсэл/

Сумын Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/137 тоот “Бог малын мялзан өвчний вакцинжуулалтыг зохион байгуулах тухай” захирамжийг үндэслэн 93600 тун вакциныг 93600 бог малд хийж вакцинжууллаа. Дээрх ажлыг аймгийн Мал эмнэлгийн газар, Номгон захирагчийн алба, сумын ЗДТГазар, Хөх сэрхийн өвөр ББН, Цөм сүрэг МЭҮНэгжүүд хамтран зохион байгуулав.

Соёл урлагийн чиглэлээр:Засаг даргын Тамгын газар нь Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах баярын өдрийг тохиолдуулан төр төсвийн 13 байгууллагатай хамтран 06 дугаар сарын 01-ний өдөр “Нэгдүгээрт хүүхэд” арга хэмжээг зохион байгууллаа.

Тус арга хэмжээний хүрээнд баярын хөтөлбөр боловсруулан хүүхэд багачуудад Соёлын ордны уран бүтээлчдийн бүтээл “Модон зам” хүүхдийн жүжиг Соёлын ордонд үнэ төлбөргүй тоглож, сумын шилдэг хүүхдүүдийн хүндэтгэлийн парад алхалт, “Алдарт эхийн одон” гардуулах үйл ажиллагаа, сургуулийн өмнөх нас болон ахлах, дунд ангийн сурагчдын урлагийн тоглолт, хүүхэд багачуудын дунд гар зургийн уралдаан, дартс, дугуйн уралдаан, буухиа тэмцээн, цоглог хүү, хөгжөөнт цагариг, ногоон гэрэл цагаан шугам тэмцээнүүдийг амжилттай зохион байгуулан сурагчдын бүтээлийн үзэсгэлэнг гарган ажилласан. Мөн хоол хүнс, худалдаа үйлчилгээ явуулж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нарт хяналт шалгалтын ажлын хэсэг гарч хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Дэд бүтэц, үйлдвэрлэл: Жимстэй хорооллын үерийн далан нөхөн сэргээх ажил 6\*600 м урттай замыг түрж тэгшилж, хажуу талын үерийн даланг нөхөн сэргээж, 2 нүхэн гүүр шинээр хийх ажлыг иргэдийн бүлэг хийж гүйцэтгэж, 06 дугаар сарын 18-ны өдөр комисс хүлээн авав.

Гавшгай хоёрдугаар багийн нутаг дэвсгэр дээр шинээр үүссэн хогийн цэг дээрх хогийг ангилах, орчныг цэвэрлэх, түрж булшлах ажлыг сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 06 дугаар сарын 18-наас 20-ны өдрүүдэд хийж гүйцэтгэв.

Номгон тосгоны 12 айлын орон сууцны дээвэр засварын ажилд “Уужимхүслэн” ХХК шалгарч тухайн байрны дээврийг мембраман хучилтаар хийж гүйцэтгэж, уг ажил 60 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.

Бичил хорооллын дундах сүүдрэвч нэмэгдүүлэх ажилд “Хөх сэрхийн мандал” ХХК шалгаран 6 талт сүүдрэвч хийхээс гадна 1-р сургуулийн урд талын ногоон байгууламжийн дунд нэг сүүдрэвч 3 тал руу гарсан явган хүний зам тавих, бүх сүүдрэвчинд шинээр хогийн сав нэмэх ажлууд хийгдэж, 50 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.

Аймгийн ОНХСангийн хөрөнгө оруулалтаар Гавшгай 2-р багт байрлах Дөмбөн хорооллын 800м урт зам болон Номгон тосгоны төв замыг хатуу хучилттай зам тавих ажилд Жинчингранд ХХК шалгаран 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн хийж гүйцэтгэн, 65 хувийн гүйцэтгэлтэй ажил явагдаж байна.

**Эрүүл мэндийн чиглэлээр:** Төр төсвийн ажилчин алба хаагчдад Эрүүл мэндийн төвтэй хамтран элэгний В, С вирусийн халдвар түүнээс урьдчилан сэргийлэх талаар сургалт сурталчилгаа зохион байгуулж гарын авлага материалыг 354 иргэнд тараан ажиллалаа.

### **Сүхбаатар сүм:**

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр буюу 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар тус сумын 48 эх алдартэхийн одонгоор шагнагдсан.

Ардын хувьсгалын 102,Сүхбаатар сумын 86-н жилийн ойн сумын баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх зорилгоор тус сум нь баяр наадмын тухай хуульд заасны дагуу сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд “Сумын баяр наадмыг зохион байгуулах хорооныбүрэлдэхүүнийг батлах тухайтогтоолын төслийг сумын Засаг даргын албан тоотоор албажуулан хүргүүлж, тус сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдөр хуралдаж, “Сумын баяр наадмыг зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай” 76 тоот тогтоолыг гаргаж, уг тогтоолыг үндэслэн сумын Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн сумын “Баяр наадам зохион байгуулах” тухай А/238 тоот захирамж гарган сумын баяр наадмыг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

“Нэгдүгээрт хүүхэд”, “Найз байя”, “Хүүхэд эрхэм хэрэглэгч”зэрэг нөлөөллийн ажлын хүрээнд Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 2023 оны 5 дугаар сарын 30-ны өдөр сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхдүүд Сэлэнгийн долгио чуулгын байранд болон Партизаны талбайдөөрсдийн хийсэн бүтээлээр үзэсгэлэн гаргаж, мөн урлагын тоглолтоор үзүүллээ.

"Модонзам" хүүхдийндуулалтжүжиг, "Ишигхэнбатүүнийнайзууд" хүүхдийндуулалтжүжгийг ерөнхий боловсролын сургуулийн бага анги, цэцэрлэгийн хүүхдүүдэд үнэ төлбөргүйгээр үзүүлсэн.

Хүүхдүүдэд үйлчилгээ үзүүлэх тоглоомын хотхонуудыг төрийн болон Төрийн бус байгууллагууд Партизаны талбайд гаргаж баярын үеэр үйлчилгээ үзүүллээ. Үүнд:

- Өсвөрийн фермер хотхон
- Өсвөрийн байгаль хамгаалагч хотхон
- Боловсролын хотхон
- Гэр бүлийн хотхон
- Эрүүл мэндийн хотхон
- Харилцаа холбоо хотхон
- Музей,Номын хотхон
- Ирээдүйн хадгаламж хотхон
- Спортын арга хэмжээний хотхон
- Музей,Номын хотхон
- Өсвөрийн эмч хотхон
- Өсвөрийн аврагч хотхон
- Өсвөрийн цагдаа хотхон
- Хилчин хотхон

- Өсвөрийн төмөр замчин хотхон
- Урлагын тоглолт
- Худалдаа үйлчилгээ

Баярын арга хэмжээний үеэр 2022-2023 оны хичээлийн жилд урлаг спорт, авьяас чадвараа дайчлан анги хамт олноо манлайлан амжилт гаргаж тив, улс, бүсийн тэмцээнд оролцож нутаг орныхоо нэрийг гаргасан сумын 35 хүүхдэд “Сумын шилдэг хүүхэд” шагналаар шагнасан.

Уламжлал ёсоор жил бүр зохион байгуулагддаг 6-р сарын 1-нд төрсөн болон ихэр сумын хэмжээнд нийт 201 хүүхдэд гарын бэлэг гардуулсан.

Хөгжлийн бэрхшээлтэй болон зорилтот өрхийн нийт 360 хүүхдүүдэд гэрээр бэлэг тараах ажлыг багийн Засаг дарга нийгмийн ажилтнууд зохион байгуулсан.

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Миний ертөнц-Миний мөрөөдөл” удирдамжийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй 24 хүүхэд оролцуулан гар зургийн уралдааныг зохион байгууллаа. Мөн байнгын асаргаанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй 26 хүүхдэд гэрийн эргэлт, үзлэг хийж гарын бэлэг тараасан.

Мөн хүүхдүүдийн дунд унадаг дугуй, гар утас, мөнгөлөг чихрийн таваг, хүүхдийн төрөл бүрийн хувцас, цүнх, буддаг ном харандаа гэх мэт 99 хонжвортой сугалаа явуулж нийт 360 хүүхэд оролцсон бөгөөд хонжвор таараагүй хүүхдүүдэд Дэлхийн зөн Монгол олон Улсын байгууллагаас гарын бэлгийг тараасан.

Өдөрлөгийн үеэр багийн өрхийн үйлдвэрлэл эрхлэгч иргэдийн үзэсгэлэн, худалдаа гарч, Дэлхийн Зөн Монгол Олон улсын байгууллагын Сэлэнгэ Орон нутгийн хөтөлбөрөөс “Хүүхдүүдэд зурган хэлбэрээр өртөө байгуулан” Хүүхдийн эрхийн талаар сургалт зохион байгуулсан.

Аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын Сүхбаатар сумын халамжийн мэргэжилтэнтэй хамтран иргэдийн амьжиргааны түвшинг тогтоох зорилгоор тус сумын нийгмийн ажилтан, хэсгийн ахлагч нар 37 айлаар явж судалгаа авч ажиллалаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Эрүүл-Монгол-Хүн үндэсний хөтөлбөр”, “АлсынХараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх “ЭерэгХандлага-Эрүүл Нийгэм”, “Энэ Жилдээ-Эрүүл Жиндээ”, “Цаг гаргая” аяны хүрээнд эрүүл зөв, зохистой хооллолт, идэвхтэй дасгал хөдөлгөөний ач тус, иргэн бүрд эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн Спорт-Өдөрлөгийг 2023 оны 06 дугаар 02-ны өдөр аймгийн Засаг даргын Тамгын газар, Биеийн тамир, спортын газар, Эрүүл мэндийн газар хамтран тус сумын “Партизаны талбай”-д зохион байгууллаа.

“Спорт өдөрлөг”-ийн үеэр Монголын Хүүхдийн спортын зуны VII наадамд оролцох баг тамирчдад хүндэтгэл үзүүлж, аймгийн тугийг өсвөрийн тамирчдад гардуулж аймаг орон нутгийнхаа нэрийг гаргаж, амжилттай оролцохыг хүслээ.

Мөн энэ үеэр спортын өсвөрийн тамирчдын үзүүлэх тоглолт болон нийтийн бүжиг, шугаман бүжгийн үзүүлбэрүүд, дасгал хөдөлгөөн түүний ач холбогдол, эрүүл зөв хооллолтын зөвлөмж, сургалтууд явагдсанаас гадна сумдын спортын цогцолборууд, “Тэс фитнес” клуб, спортын холбоодууд үйл ажиллагаагаа танилцуулж сурталчилсан бол Сагсан бөмбөгийн 3х3 тэмцээнийг 12 ангийн сурагчдын дунд зохион байгуулсан байна.

Тус арга хэмжээнд тус сумын 8-н баг болон Өрхийн эрүүл мэндийн төвүүд, сумын ахмадын хороо, ахмад настнууд, спорт, бүжиг, дугуйн холбоодууд, аж ахуй нэгж, байгууллага, ард иргэдийн төлөөлөл идэвхтэй оролцлоо.

Аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газраас олон нийтийн оролцоонд түшиглэсэн сэргээн засах үйлчилгээг 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдөр “ЭБУС”, “Энэрэлт үйлс” эмнэлэгт зохион байгуулж тус үйлчилгээнд ахмад настан - 4, хөгжлийн бэрхшээлтэй иргэн -3 иргэн хамрагдсан.

Аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газартай хамтран оёдолчны сургалтад 3 иргэнийг хамруулж үнэмлэх олгосон.

Хөдөө аж ахуй, байгаль орчны хүрээнд: Сэлэнгэ аймаг Япон Улсын Шизуока муж хоорондын хамтын ажиллагааны хүрээнд Япон улсын Шизуока мужийн Засаг даргын Тамгын газрын газар тариалан, ойн аж ахуйн чиглэлийн 4 ахлах мэргэжилтэн, судлаачид тус суманд албан ёсны айчлал хийж ажиллалаа. Хүнсний ногооны тариалан эрхлэгч 39 иргэн сургалтад хамрагдаж Боргүвээ 5 дугаар баг, Буур хээр 8 дугаар багийн 3 өрхийн талбайтай танилцаж, дадлагын сургалт хийлээ.

Япон улсын хүлэмжийн аж ахуйн өнөөгийн байдал, сайн туршлага, хүлэмжид тариалагдаж буй хүнсний ногооны тариалалтад анхаарах асуудал болон өвчин, хортонтой тэмцэх, бордоог боловсруулах хэрэглэх аргын талаар тариалан эрхлэгчид туршлага судлалаа.

Сумын хэмжээнд төмс 43 га, хүнсний ногоо 32,5га-д тус тус тариалаад байна.

2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн сумын Засаг даргын “Дархлаажуулалтын ажил зохион байгуулах тухай” А/213 тоот захирамжийн хүрээнд бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын вакциныг сумын хэмжээнд зохион байгуулж 14100 бог малыг вакцинжуулалтад хамрууллаа.

Сумын Засаг даргын А/194 тоот захирамжаар “Хүлэмжийн агро парк” байгуулах ажлын хэсэг байгуулагдаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулан, тус суманд одоогоор 24 иргэн “Хүлэмжийн аж ахуйн агро парк байгуулах төсөл”-ийн шаардлагыг ханган шалгарсан байна.

Сүхбаатар сумын Боргүвээ 5-р багийн нутаг дэвсгэр, олон улсын зам дагуу байрлалд “Хүлэмжийн аж ахуйн агро парк байгуулах төсөл” хэрэгжихээр болж 6:10 харьцаатай 35 хүлэмжийг гүйцэтгэгч байгууллагад хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газартай хамтран “Хөдөлмөрт бэлтгэх сургалт”, “Хүлэмжийн аж ахуй эрхлэх” онол, дадлага хосолсон сургалт зохион байгуулж, зорилтот бүлгийн 20 иргэнийг хамруулан сертификаттай болгосон.

Шаамар суманд зохион байгуулагдсан “Зөгийн балын мөшгөх системийг нэвтрүүлэх” сургалтад зөгийн аж ахуй эрхлэгч 6 иргэн оролцлоо.

### **Түшиг сүм:**

Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд:

-Олон хүүхэд төрүүлж өсгөсөн ээжүүдийг Алдарт эхийн 1,2-р одонгоор шагнаж урамшуулан хүндэтгэл үзүүлэх

-6-р сарын 1-ний өдөр төрсөн хүүхэд, аав, ээжид хүндэтгэл үзүүлэх

-Дугуйн тэмцээн, Манцуйтай тамирчин, “Аз жаргалтай гэр бүл” зургийн уралдаан, “АХА” зэрэг тэмцээнүүдийг зохион байгуулж ЗДТГ, Соёлын төв, сумын Эмэгтэйчүүдийн салбар зөвлөл хамтран ажиллалаа.

-Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ЗДТГ-ын албан хаагчдын хүүхдүүдийн дунд 5 төрөлт спортын тэмцээн зохион байгуулж, шагналын санд 280000 төг зарцуулан тус уралдаан тэмцээнүүд эрүүл мэнд, идэвхтэй хөдөлгөөнийг дэмжиж нийт 50 гаруй хүүхдүүд хамрагдлаа.

-Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын А/242, Соёл урлагийн газрын даргын А/76 тоот хамтарсан тушаалаар баталсан “Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журам”-ын хэрэгжилтийг ханган ажиллах хүрээнд Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэх үйл ажиллагааны зардалд нийт 1602000 төгрөгийг зарцууллаа.

Хөдөө аж ахуйн салбарын хүрээнд: 2022 оны жилийн эцсийн мал тооллогоор 56461 толгой мал тоологдож 2000 толгой буюу 3,5%-иар нэмэгдсэн байна. Үүнээс

Адуу- 3217 толгой мал

Үхэр-10885 толгой мал

Хонь-24265 толгой мал

Ямаа-16087 толгой мал тоологдсон байна. Өсөлт, бууралтыг тус бүрээр авч үзвэл:

Адуу-269 толгой буюу 8,3%-иар өссөн

Үхэр -413 толгой буюу 3,7%-иар өссөн

Хонь-759 толгой буюу 3,1%-иар өссөн

Ямаа-566 толгой 3,5%-иар өссөн

“Хүнсний ногоо тариаланчдын зөвлөгөөн-2023” арга хэмжээ зохион байгуулагдан нийт 7 ногоочин, 2 жимс, жимсгэн тариалдаг иргэн тус тус хамрагдсан. Сумын хэмжээнд 28 га талбайд тариалалт хийх төлөвлөгөөтэйгээс 28.1 га талбайд төмс тариалалт хийн 100%-тай байна. Хүнсний ногоо 26 га талбайд тариалалт хийх төлөвлөгөөтэйгээс 26,2 га тариалалт хийж 100%-тай тариалалт хийгдсэн байна.

Энэ оны хавар үр тариа, тэжээл тосны ургамал, төмс, хүнсний ногоо тариалах төлөвлөгөөг аж ахуйн нэгж, иргэний судалгааг гарган, нийт тариалах талбай 12907 га талбайгаас үр тариа 8955 га талбайд тариалах төлөвлөгөөтэй байна. Үр тарианы тариалалт 58,1%-тай явагдаж байна. 10803 га талбайд тариалалт хийснээс 6431 га үр тариа үүнээс:

-Улаан буудай 6169 га талбай

-Овьёос 116 га талбай

-Тэжээлийн ургамал 3112 га талбай

-Рапс 1260 га талбайд тус тус тариалалт хийгдэж байна.

Байгаль орчны салбарын хүрээнд: Хуурайшилтын хугацаа дуусч ойн мэргэжлийн байгууллагууд мод бэлтгэхээр ММЭ Түшиг ХХК Улаалзганатын аманд 200 м3 нарс арчилгаа, Мойлт нуга ХХК-нд Ороохын аманд шинэс мод тээвэрлэлт, УБТЗ МБҮйлдвэр Хужиртын энгэрт 280 м3 шинэс үйлдвэрлэлтийн огтлолоор тус тус бэлтгэхээр талбай тусгаарлалт хийгээд байна.

2019 оноос хойш хийгдээгүй байсан уст цэгийн тооллогыг Сэлэнгэ голын сав газрын захиргаанаас томилогдсон ажлын хэсгийн хамт 06 сарын 12,13-ны өдрүүдэд хийсэн, тооллогын дүн гараагүй байна.

Эрүүл мэндийн салбарын хүрээнд: Нийт 1070 үзлэгээс урьдчилан сэргийлэх 419 буюу 39,1% идэвхитэй хяналт 140 буюу 13% гэрийн идэвхтэй эргэлтээр 88

буюу 8,2% амбулатори 397 буюу 37,1% эмнэлэгт 93 хүнийг 621 ор хоногоор үйлчлэн хэвтүүлэн эмчилсэн.

Сумын хэмжээнд нийт 18 эх төрснөөс сумандаа 4, нарийн мэргэжлийн эмчийн хяналтанд 14 эхийг шилжүүлэн төрүүлсэн, жирэмсний хяналтанд 11 эхийг шинээр авч, эхний 3 сартай хяналт 11 буюу 100% гэрийн төрөлт 1 бүртгэгдэж эх, нярайн эндэгдэлгүй ажиллаж, одоо жирэмсний хяналтанд 14 эх хянагдаж байна.

Осол гэмтлийн өвчлөл 17 тохиолдол бүртгэгдсэний 0-18 насны 5 хүүхэд байна. Түргэн тусламжийн 170 дуудлага хүлээн авснаас алс 23 ойрын 147 осол гэмтлийн 5 дуудлагад шуурхай үйлчилсэн байна.

### **Хушаат сум:**

Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/293 тоот захирамжын дагуу сумын Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/59 тоот захирамж гарган сумын хагас жилийн мал тооллогын түүвэр судалгааг 2023 оны 05 дугаар сарын 30-наас 06 дугаар сарын 06-ны өдрүүдийн хооронд зохион байгуулсан. Сумын хэмжээнд 56 өрх, 2 аж ахуйн нэгж өайгууллагын нэр түүвэрлэгдэн ирж нийт 20181 толгой мал тоологдсон. Үүнд:

- Адуу-1133
- Үхэр-3137
- Хонь-10639
- Ямаа-5272 толгой мал тус тус тоологдсон.

Төл бойжилт сумын хэмжээнд нийт 37508 төл /унага 841, тугал 3783, хурга 19004, ишиг 13880/ эсэн мэнд бойжиж байна. Том малын зүй бус хорогдолын мэдээ Сумын хэмжээнд 989 том мал /адуу-56, үхэр-191, хонь-379, ямаа-363/-ын зүй бус хорогдол гарсан. Үүнээс хээлтэгч 181 том мал /гүү-10, үнээ-34, эм хонь-61, эм ямаа-76/ хорогдсон байна. Энэ сард талх 1,8 тн-ыг үйлдвэрлэсэн. Харин блок улирлын чанартай хийгддэг тул үйлдвэрлэлт эхлээгүй байна.

2023 онд улаанбуудай- 12564 га, тэжээлийн ургамал- 488 га, овьёос-207 га, тосны ургамал- 3674 га, төмс- 199 га, хүнсний ногоо- 230 га талбайд тариалалт хийгдэж байна.

### **Нийгмийн бодлогын чиглэлээр:**

- Эрүүл мэндийн төвийн 6 сарын байдлаар
- Төрөлт 0
- Нас баралт
- Ор хоног 91
- Эмнэлэгт хэвтсэн 9
- Эмнэлгээс гарсан 13
- Үзлэгийн тоо бүгд 452
- Амбулатори 94
- Урьдчилан сэргийлэх 151
- Идэвхитэй хяналт 40
- Гэрийн идэвхитэй үзлэг 140
- Гэрийн дуудлага 27
- Хяналтанд байгаа жирэмсэн 9
- Шинээр хяналтанд орсон
- 0-5 насны жинэлсэн хүүхдийн тоо 140
- Д-амин дэм уусан хүүхэд 43
- А-амин дэм уусан хүүхэд 95
- Олон найрлагат бичил тэжээл хэрэглэсэн хүүхэд 0

- Түргэн тусламжийн дуудлага 27
- Үүнээс алсын дуудлага 4
- Артерийн гипертензи эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хүний тоо 54
- Чихрийн шижин хэв шинж 2 эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хүний тоо 54
- Урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан хүүхдийн тоо 318
- Шинжилгээнд хамрагдсан хүний тоо 15
- Түргэвчилсэн эерэг 0
- PSR 0
- Умайн хавдар хөхний хавдар илрүүлэг үзлэгт хамрагдсан хүний тоо 19
- Элэгний эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан 10
- Өдөр эмчилгээнд 3
- Сэргээн засах эмчилгээнд 10
- Гэрийн эргэлт

Сумын “Нийгмийн хамгаалал ба нийгмийн бодлого” группд 5 төрлийн мэдээлэл тавьж, давхардсан тоогоор 150 иргэн үзэж судлан, танилцсан ба хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн чанарын судалгааг цахимаар зохион байгуулсан.

Хушаат сумын хэмжээнд “Нэгдүгээрт хүүхэд” олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг хөтөлбөр боловсруулан түүнийг дагуу хүүхэд багачуудыг эрсдэлээс хамгаалан зохион байгууллаа.

Гэр цэцэрлэгийн сургалт үйл ажиллагаа сургалтын хуваарийн дагуу тогтмол хүүхдийн насны онцлогт тохируулан үйл ажиллагааг явуулж байна. Хүүхдийг тоглоомын аргаар тоглуулан харилцан ярилцах, өглөө бүр хүүхдүүд зураг өгж өгүүлбэр зохиолгон хүүхдийн үгийн баялгыг нэмэгдүүлэн хүүхдээ хөгжүүлж байна. Өглөөний хүлээн авалтын үеэр шүлэг цээжлүүлэх, үлгэр ярих, зургын үйл явдлын дагуу бүдүүвч сөхмөн дагуу өгүүлбэр зохиж ярих, зураг зурах, будах 1-10 хүртэл цээжээр болон бодитоор тоолох, хувилбарт сургалтын хөтөлбөрийн дагуу сургалт үйл ажиллагааг хэвийн зохион байгуулж байна. Бүлгийнхээ эцэг эхэд Улаан бурхан, гар хөл амны өвчны талаар гарын авлага тарааж мөн салхинцэцэг өвчны талаар боршур хийж тараасан.

“СОЁЛЫН СЭРГЭЛТ-2023” аяны нээлтийн үйл ажиллагаа 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр Хушаат суманд зохион байгуулагдлаа. Аяны нээлтийг Байгалийн Түүхийн Музейн дарга И.Будбаяр, Орлогч дарга Т.Дашбат, Сумын ЗДТГ-ын дарга О.Цогбаяр, Соёлын төвийн дарга П.Энхчимэг нар нээж дараах ажлууд зохиогдлоо.

Үүнд: Байгалийн түүхийн музейн зэрлэг амьтдын чихмэлийн үзэсгэлэн, Монгол орны байгаль, ан амьтдын шилдэг зурагчны бүтээлийн үзэсгэлэн, “Байгаль бидний гэр” гар зургийн үзэсгэлэн, урлагийн тоглолт, алиалагчийн үзүүлбэр, соён гэгээрүүлэх сургалт, кино үзвэр, үдэшлэгийн арга хэмжээ хөтөлбөрийн дагуу зохион байгуулагдлаа.

Мөн энэхүү арга хэмжээнд Соёлын төвийн ажиллагсад, байгууллагын дэргэдэх бүжгийн дугуйлангийн Болор-2 хамтлагийн хамтарсан урлагийн тоглолтоор мэндчилгээ хүргэж, Аймгийн бүтээлч ардын авьяастан М. Байгальмаа өөрийн урласан шүрэн эдлэлээр үзэсгэлэн гаргаж мөн номын сангаас авьяаслаг хүүхдүүдийн Монгол бичгээр бичсэн бүтээлийн үзэсгэлэн, гар зургийн уралдааны үзэсгэлэн зэргийг иргэд, хүүхэд багачуудын хүртээл болгон ажиллалаа.

Түүнчлэн Байгалийн түүхийн музейн хамт олонд Дуут хад, түүн дээрх эртний сүг зураг болон сонин содон авиа дуугаралтыг сурталчлан танилцууллаа.



“Зуны зугаатай өдрүүд” ном унших 14 хоногийн аяны хүрээнд ном унших өдөрлөг, номын тэмдэглэл, номын утгыг ярих , дараагийн хуудас буюу зохиол үргэлжлүүлэх зэргийг зохион байгуулан ажиллаж байна.

Хөдөө аж ахуйн чиглэлээр: 2023 онд улаанбуудай- 12564 га, тэжээлийн ургамал- 488 га, овъёос-207 га, тосны ургамал- 3674 га, төмс- 199 га, хүнсний ногоо- 230 га талбайд тариалалт хийгдэж байна. Төмс, хүнсний ногоо, тариалангийн талбайг малаас хамгаалах гурвалсан гэрээг Ар тойлбо чиглэлийн 3 ААН-ийн захиралууд болон багийн даргатай хамтран явж 54 айл өрхтэй гэрээ байгуулан ажиллалаа.

Хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлт 6 сарын байдлаар 2,283,900 төгрөг төлөгдсөн байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд сумын газар тариалангийн аж ахуй нэгжүүдэд тариалангийн талбайг тойруулан хамгаалалтын зурвас байгуулах, айл өрх албан байгууллагуудыг ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр зөвлөмж, мэдээлэл хүргүүлэн ажилласан. Тариалангийн талбайн хамгаалалтын зурвас байгуулахаар 60000 ш /улиас, хайлаас, бургас, нарс/ мод, ногоон байгууламжийн нэмэглүүлэхээр 26 өрх 641 ш мод бут тарьсан. Мөн сумын Халамжийн мэргэжилтэнтэй хамтран нийтийг хамарсан ажлаар сумын зорилтот бүлгийн өрхийн 10 гишүүнээр 7 хоног Тарвагатайн ойн санд 5 га талбайд 3 настай 12500 ш нарсны тарьцаар ойжуулалтын ажлыг зохион байгуулж, хяналт тавьсан.

Монгол улсын засгийн газраас 2023-2025 оныг Монголд зочлох жил болгон зарласантай холбогдуулан “Эрүүл аюулгүй-Цэвэр орчин” бүрдүүлэх арга хэмжээний тухай БОАЖЯ-ны сайдын 2023.02.28-ны 02 тоот албан даалгавар, Сэлэнгэ аймгийн Засаг даргын А/156 тоот “Бүх нийтийн хог цэвэрлэгээ арга хэмжээг зохион байгуулах тухай” захирамжийн хүрээнд Бүх нийтийн хог цэвэрлэгээг 2 дугаар улиралд 3 удаа зохион байгуулан төр, төсвийн албан байгууллага, аж ахуй нэгж, иргэдийг хамруулан нийтийн эзэмшлийн зам, талбай, Орхон хорооллын урд болон Орхон гол, Ишгэнт нуур орчмын хог хаягдлыг цэвэрлэж ажилласан. Бүх нийтийн цэвэрлэгээнд төр төсвийн 5 албан байгууллагын 86 албан хаагч, 6 аж ахуй нэгжийн 28 ажилтан, 2 багийн 96 айл өрхийн 126 иргэн оролцож 20 тн хогийг түүж, тээвэрлэн төвлөрсөн хогийн цэгт хүргэж ажиллалаа. Мөн ОНХС-ын хөрөнгө оруулалтаар хогийн цэгийн тархалтыг багасгаж, түрж дотогшлуулах ажилд хяналт тавьж ажилласан.

Нийт 12 аж ахуй нэгжид шаардлагад нийцсэн эко жорлонтой болох зөвлөмж хүргүүлсэн. Нийт 3 аж ахуй нэгжийн нүхэн жорлонг буулгуулсан. Гэр хорооллын айлуудад сайдын албан даалгаварыг танилцуулж, сумын хэмжээнд 2 багийн иргэдэд давтагдсан тоогоор нийт 138 иргэнд тараах материалыг тарааж өгсөн.

Зүй бусаар болон байгалийн гамшгийн улмаас хорогдсон мал, амьтны сэг зэмийг мал эмнэлгийн байгуулагатай хамтран сэг зэмийг устгах булшлах ажлыг гүйцэтгэсэн байна.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын А/134 тоот Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний тухай, сумын Засаг даргын А/60 тоот Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх тухай ажлын хүрээнд Байгалийн гэнэтийн гамшиг осолтой тэмцэх урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд шар усны үер болон ой хээрийн түймрээс сэргийлэх санамж сэрэмжлүүлгийн хуудсыг 200 ш хэвлэн

тарааж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажилласан. Байгаль хамгаалагч, багийн Засаг дарга нартай хамтран ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлгийг 206 өрхөд, үр тарианы чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 12 ААН нийт 218 санамж сэрэмжлүүлгийг тараасан байна. Мөн Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зурагт самбарыг Хашаатын даваа, Мэргэний даваа, Сэнстэйн даваа зэрэг газруудад байрлуулсан. Хууль бус загасчлалаас урьдчилан сэргийлэх зорилгоор Орхон голын эрэг дагуу 2 удаа хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж 6 тээврийн хэрэгсэл, 32 иргэнд зөвлөмж, мэдээлэл хүргүүлэн ажиллалаа.

### **Хүдэр сум:**

Сумын хэмжээнд 2 тэрбум 336 сая төгрөгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй 11 ажил, арга хэмжээний ажлын явцтай танилцаж 58,3 %-тай явагдаж байна. Сумын төв хүртэл 9,2 км хатуу хучилттай замын ажлын явц 75%, сумын төв доторх замын ажил 85 %-тай явагдаж байна.

Тарвагатай 1-р багийн иргэдийн нийтийн хурал 46,2 хувийн ирцтэй хуралдаж 2024 онд орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх ажил үйлчилгээг эрэмбэлэх саналыг иргэдээс авч баталгаажуулсан.

Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагаас сумын “Иргэний нийгмийн байгууллагуудын чадамжийг үнэлэх ” уулзалт зохион байгуулж иргэний нийгмийн 25 гишүүн хамрагдлаа.

**Санхүүгийн талаар:** Орон нутгийн орлогын төлөвлөгөө 06-р сарын байдлаар өссөн дүнгээр 508,089,0 мянган төгрөг батлагдсанаас 952,634,2 мянган төгрөг орж орлогын төлөвлөгөө 533 хувиар биелсэн дүнтэй байна. Нийт 1,301.169.3 мянган төгрөг батлагдсанаас 582.619.6 мян төгрөг зарцуулсан дүнтэй байна.

**Хөдөө аж ахуйн талаар:** Сумын хэмжээнд мал бойжилтын мэдээ унага -806, тугал-4125, хурга-5375, ишиг-4536 нийт -1586 төл мал бойжиж нийт төллөх малын 89 хувь төллөсөн байна. Энэ сарын байдлаар мал хорогдоогүй байна.

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар болон Эрүүл мэндийн газар хамтран сумын хэмжээнд худалдаа үйлчилгээ эрхлэгч нарын тусгай зөвшөөрөл, стандарт, эрүүл ахуй, өргөн хэрэглээний барааны үнэ, халдваргүйжүүлэлт, ариутгал, барааны хугацаанд хяналт тавьж заавар зөвлөмийг 33 иргэнд хүргэж ажилласан.

Мал эмнэлгийн нэгдсэн сан-2.0 шинэчлэгдсэн, хувилбар 2023 оны 01 сарын 01-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн бөгөөд тайлант сард 33 удаагийн гэрчилгээг цахимаар баталгаажуулж гарган, иргэдэд хөнгөн шуурхай үйлчилгээ үзүүлэн ажиллаа. Үүнд: Адуу 20 толгой, үхэр 32 толгой, хонь 21 толгой, ямаа 6 толгой, адууны мах 100 кг, үхрийн мах 2020 кг, хонины мах 15кг, 1135 кг, тус бүр эрүүл мэндийн гэрчилгээ олгож хяналт тавин ажилласан.

Эрт илрүүлэг үзлэгийн идэвхгүй тандалтын мэдээллийг мал эмнэлгийн нэгдсэн системд шивэлт хийж оруулах ажилд нийт 20 өрхийн суурьт 4500 үхэр сүргийн 210, бог малын мялзангийн тандалт 15 өрхийн 6400 толгой малын 461 толгойд түүвэрчлэн хийж гүйцэтгэв.

Мал амьтны гоц халдварт бог малын мялзан өвчний гаралт тархалтаас урьдчилан сэргийлэх Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/02 дугаар тушаал, Мал Эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2023 оны 05 дугаар ссарын 19-ний өдрийн “Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх нэгдсэн дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах туха” А/125 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2023 оны А/303, сумын засаг даргын А81, А/82, А/83 дугаар

захирамжуудийн хүрээнд сумын хэмжээнд бог малыг яаралтай дархлаажуулах ажил хийгдэж, 25500 толгой мал хамрагдаж гүйцэтгэл 89 хувьтай явагдаж байна.

Байгаль орчны талаар:2023 оны сумын байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг сумын ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжилтийг хангуулан хагас жилийн байдлаар 42,5 хувийн гүйцэтгэлтэй байна. Батлагдсан удирдамжийн дагуу төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 2 удаа хийж гүйцэтгэсэн. Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2016 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/133 дугаар тушаалаар батлагдсан Ойгоос мод бэлтгэх журмын хэрэгжилтийг хангуулах, Хяналт шалгалтанд хамрагдсан аж ахуй нэгжүүдэд илэрсэн зөрчлийг арилгуулах, мод бэлтгэсэн талбайн цэвэрлэгээг бүрэн гүйцэт хийж актаар хүлээлгэн өгөх тухай хугацаатай албан шаардлага хүргүүлэн ажилласан.

Хяналт шалгалтын явцад огтлолтын төрөл өөрчлөн эрхийн бичигт заасан хэмжээ хэтрүүлэн зохих зөвшөөрөлгүй мод бэлтгэсэн 2 аж ахуй нэгжийг холбогдох байгууллагад шилжүүлэн хэрэг бүртгэл нээн шалган шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас Ойн тухай хууль тогтоомж зөрчин гарал үүслийн гэрчилгээгүй мод модон материал тээвэрлэж явсан 2 иргэнээс хураасан 53 м3 модыг сумын захиргааны журмаар хураагдсан эд зүйлс хураан авч устгалд оруулах ажлын хэсэгт хүлээлгэн өгч ажилласан.

Цагдаагийн байгууллагаас харьяаллын дагуу 7 аж ахуй нэгжийн материал шилжүүлсэнтэй холбогдуулан Хүдэр очир, Хүдэр амжаа, Хүдэртэйн буян, Тарс, Хүдэр төгөл, Хүдэр нумт, Хүдэр дэлгэрэх ХХК-иудад ЗШШАжиллагаа явуулан ЗТХуулийн 7.9 -р зүйлийн 3 дахь заалтын дугуу арга хэмжээ авахаар хэргийн газрын үзлэг хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэж байна.Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хяналт шалтгалтыг 1 удаа хийсэн. Хяналт шалгалтын явцад Баянцагаан 2-р багийн нутаг дэвсгэр болох Цагаан Зүрийн гол дагуу зохих зөвшөөрөлгүй хууль бусаар техник хүн хүчээ төвлөрүүлсэн 8 иргэнийг бүртгэлжүүлэн техник хэрэгсэлээ татан буулгах тухай албан мэдэгдэл өгч ажилласан.

Халамжын талаар:Тайлант сард нийгмийн халамжийн 6 төрлийн үйлчилгээнд цахимаар хүсэлтийг хүлээн авч, нийт 7,164,272.0 /долоон сая нэг зуун жаран дөрвөн мянга хоёр зуун далан хоёр /мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон.

Хүнс тэжээл хөтөлбөрт хамрагдаж буй 10 өрхөд 743.0 /долоон зуун дөчин гурванмянган/төгрөгийн хүнсийг олгож байна. Хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуйн чанарын шаардлага болон үйлдвэрлэсэн хугацаанд хяналт тавин ажиллалаа.

Нийтийг хамарсан ажил арга хэмжээний хүрээнд иргэд өөрсдийн амьдарч буй орчин болон нийтийн эзэмшлийн 1,4 км засмал замын хажуу шороог цэвэрлэх , 5 ш усны хоолой цэвэрлэх, 16 хэсгийн 800 метр ногоон байгууламж модыг өдөр бүр услах ажилд дэмжлэг үзүүлэх замаар ажлын байраар хангаж, өрхийн орлогыг нэмэгдүүлж ажиллалаа.

Газрын талаар:Иргэнд газар өмчлүүлэх хуулийн хүрээнд газар өмчлөх хүсэлт өгсөн 20иргэнд 47189м2 газрыг өмчлүүлж мэдээллийн санд бүртгэж ажиллалаа.

Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа дууссан эзэмшилийн 12 нэгж талбар, ашиглалтын 1 нэгж талбарын газар эзэмших гэрээг дүгнэн газар эзэмших эрхийг сунгасан байна.Худалдах худалдан авах гэрээний үндсэн дээр газар

өмчлөх эрхээ шилжүүлэх хүсэлт гаргасан 17 иргэний хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн.

Улсын бүртгэлийн талаар: Тайлант сард төрсний бүртгэлд хүүхэд бүртгүүлээгүй, төрсний гэрчилгээгээ хаяж үрэгдүүлсэн 2 хүүхэд дахин гэрчилгээгээ авсан байна. Иргэний цахим үнэмлэхний бүртгэлд 16 насанд хүрсэн шинээр 1 сунгалт хийлгэсэн 3 иргэн тус тус байна. Мөн хэвлэгдсэн цахим үнэмлэхээ хүлээн авсан 4 иргэн байна.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн анхны бүртгэл газрын гэрчилгээг 11 иргэнд гаргаж өгч үйлчилсэн байна. Энэ сард нийт 129 иргэнд бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн байна. Нас барсны бүртгэл 2 иргэнийг бүртгүүлсэн байна.

Боловсролын талаар: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны "Журам батлах тухай" А/425 тоот тушаалаар батлагдсан "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам"-ын дагуу 2022-2023 оны хичээлийн жилийн анги дэвших шалгалтыг зохион байгуулж шалгалтанд 628 суралцагч хамрагдаж гүйцэтгэл 72-87 хувьтай байна. Бага боловсрол эзэмшигчдээс Монгол хэл Математик байгалийн ухааны нэгдмэл агуулгаар авсан 2 бүлгийн 54 суралцагч хамрагдаж гүйцэтгэл 82 хувьтай байна.

Эрүүл мэндийн үйлчилгээний талаар: Нийт эмчийн үзлэг 492 хийгдсэнээс 307 буюу 62,3 % хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 151 буюу 30.1 хувийг өвчний учир амбулаторт, 21 буюу 4.2 хувийг идэвхитэй хяналтын үзлэг, 13 буюу 2.6 хувийг гэрийн үзлэг эзэлж байна. Амбулаторийн үзлэгийн 41.6 хувийг их эмч, 27.3 хувийг эх баригч, 31.1 хувийг бага эмч үзлэг хийж оношлогоо эмчилгээг шийдвэрлэсэн байна.

Тайланд сард 51 түргэн тусламжийн дуудлага хүлээн авч 2 буюу 3.9 хувийг алсын дуудлага, 1.9 хувийг осол, гэмтлийн дуудлага 94,2 өвчний учир дуудлага байна. Хүлээн авах яаралтай тусламжийн тасагт 38 үйлчлүүлэгч үйлчлүүлсэн. Хэвтэн эмчлэх тасагт 22 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлж 154 ор хоног ашигласан байна. Орны фонд ашиглалт 10.2 хувь, дундаж ор хоног 7, орны эргэлт 1.6 байна.

### **Шаамар сум:**

Засаг даргын А/56 тоот захирамжаар "Хоггүй цэвэрхэн Шаамарчууд" аяныг 04 дүгээр сарын 03-ний өдрөөс, 06 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл 2 сарын хугацаатайгаар зарлаж, аяны хүрээнд 7 хоног бүрийн "Баасан гариг"-ийг Бүх нийтийн цэвэрлэгээний өдөр болгон ажиллаж байна.

Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журмын дагуу ЗЭБ№1 маягтыг гаргах Орон нутгийн 13 байгууллагын батлагдсан төсөвийн хуваарийг үндэслэн 06 сарын 20-ны дотор ЗЭБ№1 маягтыг Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журмын дагуу гаргаж баталгаажуулав.

Хүнс авдаг 9 өрхийн 66 гишүүнд 2023 оны 06 дугаар сарын хүнсний тэтгэмж болох 768,000 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг гэрээт байгууллага болох "Бүтээл сан" ХХК-ийн "Шонхлой" хүнсний дэлгүүртэй хамтран олгож олгосон тайланг холбогдох мэргэжилтэнд хүргүүлж ажиллалаа.

Сумын 8-н хүнсний дэлгүүрүүдээр малын гаралтай хүнсний бүтээгдэхүүнд хүнсний аюулгүй байдалд хяналт шалгалт хийж гарсан зөрчлийг тухай бүрд нь арилгуулж 2 удаа ажилласан.

Малын гоц халдварт A/01 өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажлыг цаг тухай бүрд нь эхэлж вакцинжуулалтын ажил дуусч байна. Сэг зэм устгалын захирамж гаргуулж, Багийн Засаг дарга, Мал эмнэлгийн Улсын байцаагч, Байгаль хамгалагч, малчидтай хамтран 2023 оны 6-р сарын 3-ны өдөр үхэр-40, хонь-25, ямаа-25, толгой малын сэг зэмийг устгаж 2023 оны 6-р сарын 17-ны өдөр үхэр-50, хонь-34, ямаа-18 шатааж устгасан.

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын нутаг дэвсгэрт бүх төрлийн согтууруулах ундаа худалдан борлуулах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй 6 хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийв. Хяналт шалгалт хийхдээ удирдамж танилцуулж, зарим хүнсний дэлгүүрийн үйл ажиллагааг түр зогсоож шалгалт хийсэн.

Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжигдэн “Мөнх ногоон тал” ХХК-иас нийлүүлсэн түрээсийн хүлэмжийг хөнгөлөлттэй нөхцлөөр 50 өрхөд гэрээ хийж хүлээлгэн өглөө.

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН

ГАЗРЫН ДАРГА

Ө.СУВДАА

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИДЛАГЫН

ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Б.МӨНХЖАРГАЛ